



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 - 49

- 1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/* 5 - 49

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
10 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл***

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 33 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Т.Аубакир, Х.Ганхуяг, Н.Учрал;
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Адъяасүрэн, Г.Дамдинням;
Тасалсан: С.Чинзориг.*

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд Б.Бат-Эрдэнэ, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Соёлын дэд сайд М.Батбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Энх-Амгалан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын аудитын менежер Х.Баярмаа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Ж.Алтантуяа, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дашням, Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Очиртогтох, Боловсрол, шинжлэх ухааны сайдын Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөх П.Оюунаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Х.Тамир, мөн яамны Мэргэжлийн

болон техникийн боловсролын газрын дарга А.Халиунаа, Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийн газрын дарга Д.Баттогтох, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Билэг-Өрнөх, Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Цолмон, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын дарга Ш.Алтангэрэл, мөн газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Энхжаргал, Ариун цэврийн байгууламжийн төслийн зөвлөх Г.Цэрмаа, Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, мөн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Бямбасүрэн, Урлаг, уран бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Сэргэлэн, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, Соёлын бодлогын хэрэгжилтийг Зохицуулах газрын дарга Д.Наранцэцэг, Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацийн хэлтсийн дарга Г.Батхуяг, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга Э.Тэмүүжин, Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Эрдэнэцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Ц.Мөнхцэцэг, Б.Жаргалмаа, Ж.Чинбүрэн, Л.Энх-Амгалан, Б.Баярсайхан, Г.Мөнхцэцэг, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын дэд сайд М.Батбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацийн хэлтсийн дарга Г.Батхуяг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Мөнхцэцэг: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төсвийн төслийн 14.3.10. Соёлын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийн зардлыг 200.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын музейн засварт 2024 он, 200.0 сая төгрөг гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 8
Бүгд: 9
11.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төсвийн төслийн 14.3.10. Соёлын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийн зардлыг 400.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд Сэлэнгэ аймгийн соёлын салбарын тоног төхөөрөмжид 2024 он, 400.0 сая төгрөг гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 9
Бүгд: 9
0.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 07 минут үргэлжилж, 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
13 цаг 33 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Мөнхцэцэг: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд ирсэн ирцийг танилцуулж хуралдааныг эхэлье.

Хурлын дэгд зааснаар ирц танилцуулах дэгтэй байгаа.

Тийм учраас хуралдаанд ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя.

Амгалангийн Адъяасүрэн
Баянхонгор аймаг, 3 дугаар тойрог. Өвчтэй байна.

Пүрэв-Очирын Анужин
Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар тойрог. Ирсэн байна.

Тилеуханы Аубакир
Баян-Өлгий аймаг, 2 дугаар тойрог. Томилолттой байна.

Ёндонпэрэнлэйн Баатарбилэг
Архангай аймаг, 1 дүгээр тойрог. Чөлөөтэй байна.

Балжиннямын Баярсайхан
Завхан аймаг, 9 дүгээр тойрог. Ирсэн байна.

Энхбаярын Батшугар
Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар тойрог. Ирсэн байна.

Хассуурийн Ганхуяг
Баянгол дүүрэг, 26 дугаар тойрог. Гадаад томилолттой байгаа юм байна.

Гонгорын Дамдинням
Дархан-Уул аймаг, 19 дүгээр тойрог. Өвчтэй байна.

Бадарчийн Жаргалмаа
Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар тойрог. Ирсэн байна.

Цэрэнжамцын Мөнхцэцэг
Сүхбаатар дүүрэг, 24 дүгээр тойрог. Ирсэн байна.

Чинбатын Ундрам
Сэлэнгэ аймаг, 13 дугаар тойрог. Ирсэн байна.

Ням-Очирын Учрал
Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар тойрог. Гадаадад томилолттой байна.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн
Баянзүрх дүүрэг, 23 дугаар тойрог. Ирсэн байна.

Содномын Чинзориг
Өвөрхангай аймаг, 10 дугаар тойрог. Ирж яваа юм байна.

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
Хөвсгөл аймаг, 17 дугаар тойрог. Ирсэн байна.

Гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 56.2 хувьтай байгаа тул Байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хороонд хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл

мэндийн даатгалын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж, санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлэхээр байгаа.

Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр өргөн барьсан.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд алга байна.

**Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай
хуулийн төслүүд**
*/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/*

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Байнгын хорооны хуралдаанд Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Я.Самбууням Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор, Л.Мөнхцацрал Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер, Х.Баярмаа Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Б.Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ч.Чимидсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн

санхүүжилтийн хэлтсийн дарга, Ж.Алтантуяа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, Б.Дашням Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Э.Цолмон Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Б.Очиртогтох Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Л.Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Л.Цэдэвсүрэн Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Т.Ням-Очир Боловсролын Ерөнхий газрын дарга, П.Оюунаа Боловсрол, шинжлэх ухааны сайдын Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөх, Х.Тамир Дээд боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга, А.Халиунаа Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга, Д.Баттогтох Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийн газрын дарга, Б.Батцэцэг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, С.Нансалмаа Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Т.Билэг-Өрнөх Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Ж.Мягмар Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга, Т.Түмэнжаргал Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга, А.Цолмон Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Ш.Алтангэрэл Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын дарга, Д.Энхжаргал Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн, Г.Цэрмаа Боловсролын

Ерөнхий газрын Ариун цэврийн байгууламжийн төслийн зөвлөх.

Соёлын яамнаас Соёлын сайд Ч.Номин, Ч.Энх-Амгалан Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Отгонбат Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Т.Бямбасүрэн Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Б.Сэргэлэн Урлаг, уран бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Б.Даваацэрэн Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Наранцэцэг Соёлын бодлогын хэрэгжилтийг Зохицуулах газрын дарга.

Биеийн тамир, спортын Үндэсний хорооноос Б.Бат-Эрдэнэ Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд, Э.Тэмүүжин Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга, Д.Цэрэнболд Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Г.Эрдэнэцогт Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Ийм бүрэлдэхүүнтэй дээр нь нэмж Соёлын дэд сайд М.Батбаяр оролцож байна. Ийм бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын

сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч, улмаар урт хугацааны хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох **“Шинэ сэргэлтийн бодлого”** хэрэгжүүлэх боломж бүрдээд байна.

Тиймээс **“Шинэ сэргэлтийн бодлого”**-ын гол зорилтын нэг болох **“Хот, хөдөөгийн сэргэлт”**-ийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно.

Ирэх оны төсөвт боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарыг дэмжих чиглэлээр тусгасан арга хэмжээг дурдвал:

1.Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар батлагдсан Боловсролын багц хуулийн дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа багш, ажилчдад олгох, тэтгэмжид хамрагдах хүний тооны өсөлттэй холбоотой зардлыг нэмэгдүүлэх.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын төв, политехник, коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд

боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцахад шаардлагатай зардлыг төсөвт тусгах.

3.Хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлыг нэмэгдүүлэх.

4.Боловсролын зээлийн сангаас олгох сургалтын тэтгэлгийн хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн өмчийн их дээд сургуульд багш мэргэжлээр суралцагчид олгох тэтгэлэг, мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох.

5.Шинжлэх Ухааны Академи, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, судалгаа, шинжилгээний ажлыг санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийг хуваарилах.

6.Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар батлагдсан Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг дэмжих.

7.Парис 2024 зуны олимп, паралимпын наадамд Монгол Улсын шигшээ багийн 260 гаруй тамирчныг спортын 27 төрлөөр холбогдуулан бэлтгэл хийх, олимпын эрх авах болон оноо цуглуулах уралдаан тэмцээн болон олимпод оролцох тамирчдын хувцас, хэрэглэлийн зардал зэргийг төсвийн төсөлд тусгасан болно.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих багц арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч, нэгдсэн төсвийн

тэнцвэржүүлсэн орлого 25.3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27.4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2.1 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувь болж төсвийн тусгай шаардлагыг хангаж байгаа болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ирэх оны төсвийн төсөл боловсрол, шинжлэх ухаан, спортын чиглэлээр тусгасан арга хэмжээтэй танилцаж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Б.Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг хийнэ.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн хэсэгт 7 зорилтын хүрээнд хянаж үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн болно.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна. Үүнд:

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлогыг 25 их наяд 289.8 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.2 хувь, нийт зарлага 27 их наяд буюу 360.5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70.8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдлаар төлөвлөж төсөвт тусгасан байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайд 5.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 4 их наяд 259.0 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлэхээр, Соёлын сайд 402.4 тэрбум төгрөг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга 146.5 тэрбум төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зардлын дүн нь 2023 оны тодотгосон төсвөөс 1 их наяд 274.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 4 их наяд 807.9 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн нь Засгийн газраас 2024 онд нийт албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэх бодлого баримталсантай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилттой нийцэж буй ч Монгол Улсын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнээс Боловсрол, шинжлэх ухааны яам 5, Соёлын яам 4, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороо дараах 1 арга хэмжээг тусгаагүй байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам нь **Коосэн**^[яп.Коото сэнмон гакко-ахлах мэргэжлийн сургууль] сургалтын хөтөлбөрийг аймаг бүрт мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад нэвтрүүлэх, их, дээд сургуулиудын магистр, докторын

судалгааны сэдвийг төрийн болон хувийн хэвшилд хэрэгцээтэй байгаа судалгаатай уялдуулах тогтолцоог нэвтрүүлэх, судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, судалгааны үр дүнд бий болсон олон улсын эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийг нэвтрүүлэх, сургуулийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх.

Соёлын яам соёлын бүтээлч үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт татаж, контентын үйлдвэрлэлийг бизнесийн эргэлтэд оруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

Монголын үндэсний археологи, палеонтологийн угсаатны музей, лабораторийг байгуулах.

Соёлын, баримтат төвийн бүртгэлийн ажлыг эрчимжүүлж, хадгалалт, хамгаалалтын байдлыг сайжруулах.

Үндэсний урлагийн их театрын шинэ барилгыг барих.

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороо нь биеийн тамир, спортын байгууламж, талбай, тоног төхөөрөмжийг хангах гэсэн асуудлууд байна.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн багцад 937.2 тэрбум төгрөгийн 484 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөснөөс хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 444.9 тэрбум төгрөгийн 306 төсөл, арга хэмжээ тусгагдсан 492.4 тэрбум төгрөгийн 178 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна.

Үр дүнд чиглэсэн төсөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг, мөн салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлснээс бий болох үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож, хүрэх үр дүнг нь богино, дунд хугацаагаар тодорхойлж үйл ажиллагааг хэмжсэнээр төсвийн зардлын ашиглалт, үр өгөөж нэмэгдэх, төсөвлөсөн хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд аудитаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөл хүргэж болзошгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй. Арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар

зүйлийн 18.18 дахь заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн төсөл арга хэмжээний барилга, байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, нэг маягийн болон жишиг магадлалтай 153 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах улсын комисс, барилга байгууламжийг хүлээж авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүгдийг дараах асуудалд толилуулж байна.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгуулахад анхаарах.

Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

-Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төслийг боловсруулах тухайн үе дэх хүчин төгөлдөр мөрдөгдөж буй

төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх;

-Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх;

-Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төсөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжтой нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч хэрэгжилтэд нь хяналт тавих;

Хөгжлийн бодлогод нийцүүлэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж, чадавхыг сайжруулах шаардлагатай байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Ц.Наранчимэг аудитад баярлалаа.

2024 оны төсвийн төслийг Улсын Их Хурлын Тамгын газраас хэвлэж Та бүхэнд хүргүүлсэн.

Ингээд хууль санаачлагчдаас болоод Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгье.

Ж.Чинбүрэн гишүүнээр тасаллаа.
Ч.Ундрэм гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрэм: Сая аудитын дүгнэлттэй танилцаж байхад төсөв маань

улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй бас уялдаагүй нэлээд ажлууд байна гээд дүгнэлт байна.

Жишээлэх юм бол, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяанд **Коосэн** сургалтын хөтөлбөрийг аймаг бүрт мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад нэвтрүүлэх гээд энэ ажил дээр тусгайлан тавьсан дүн байхгүй байна гэсэн ийм асуудал байна.

Дээрээс нь, сургуулийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх гээд 2021 оны төсөв дээр л Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд бид санал оруулаад батлуулж байсан. Одоо бид 2024 оны төсөв ярьж байна. Энэ ажил маань ер нь явц нь ямар байгаа юм бэ?

Үүнийг тухайн жил бид 2021 онд Улсын Их Хурлын тогтоолд хоёр жилийн дотор багтааж дуусгана гэж өгч байсан. Одоо тэгээд хоёр жил нь дуусаж байна.

Тэгэхээр үүнтэй холбоотой явц ямар байгаа юм? Ирэх жилийн төсөвт мөнгө төгрөг хэрэггүй, энэ жил ингээд дуусчаж байгаа юм уу гэдэг асуудал байна. Одоо 819 сургууль, цэцэрлэг тэнд чинь хэдэн арван мянган хүүхэд жил болгон сурч байгаа шүү дээ. Энэ 21 аймагт.

Тэгэхээр энэ ажил дээр нэлээн анхаарал хандуулмаар байна гэж бодож байна.

Дараа нь, Шинжлэх Ухаан Технологийн Сантай холбоотой, бас их дээд сургуулиудтай холбоотой байх гэж бодож байна. Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл,

патентыг эдийн засгийн эргэлтэд оруулна гэсэн.

Үүнтэй холбоотой хоёр, гурван заалт байгаад байгаа юм.

Тэгэхээр үүнтэй холбоотой юм өмнө нь хийгдэх үү? Ирэх жил юу хийгдэх юм бэ гэдэг асуудал байна.

Шинжлэх Ухаан Технологийн Сан дээр 10 гаруй хүрээлэн байна. Эд нар ер нь ямар үр дүнтэй ажиллаж байгаа юм? Та 500 гаруй хүрээлэнгийн ажилчдын ажлын үр дүнг яг ямар үзүүлэлтээр хэмждэг юм бэ гэсэн асуулт байна.

Соёлын яамтай холбоотой. Би хэдэн ч жил асуух юм бүү мэд. Манай Сэлэнгэ аймгийн Ардын хувьсгалын өлгий нутаг Алтанбулаг сумын музейн засвар гээд л 100 сая төгрөг. Нөгөө цонхны цаанаас чихэр долоолгоно гэдэг шиг л жил болгон худлаа яриад явж байгаа.

Тэгээд энэ ажлыг яах юм бэ? Соёлын яам гэсэн ийм хэдэн асуулт байна.

Г.Мөнхцэцэг: Ч.Ундрам гишүүний асуултад Л.Энх-Амгалан сайд эхлээд хариулаад явчихъя.

Л.Энх-Амгалан: Бид “Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв” гэж ярихаа больсон. Шинэ хуулиар “**мэргэжлийн сургууль**”, “**техникийн сургууль**” гэж тодорхойлолттой болсон байгаа.

Тэгээд цаашдаа бид ерөнхийдөө мэргэжлийн болон техникийн сургуулиудаа Японы **Коосэн**^[яп.高専-технологийн коллеж] загварыг ер нь нэвтрүүлэх нь дээр юм байна гээд. Ингээд 2024 оны

Улсын Их Хурлаас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөө дээр 10 мэргэжлийн техникийн сургуулиудыг **Коосэн** загварт шилжүүлнэ гэдэг шийдвэр гаргасан.

Гэхдээ энэ оны төсөвт бид багтаж 6-г хийж байгаа. Ч.Ундрам гишүүн ээ.

Тэгэхдээ эх үүсвэр нь ЖАЙКА-гийн нөгөө “**Мянган инженер**”-ийг сургаж байгаа төсөл байгаа шүү дээ. Тийм ээ. Тэр төслийн 10 тэрбум орчим төгрөгийн үлдэгдэл гарсан юм. Тэгээд үлдэгдэл дээр бид ярьж байгаад хөдөө орон нутаг дээр байж байгаа Өмнөговь, Дархан дээр байгаа, тэгээд Улаанбаатар хот дээр байгаа 3 Коосэн. Тэгээд нэмээд 6 коосэнуудыг Коосэний тогтолцоонд шилжүүлбэ. Хөтөлбөр, сурах бичгийн асуудлуудыг ингэж шийдбэ.

Японы 15 сая долларын буцалтгүй тусламжаар “**мэргэжлийн сургууль**”-ийн төвийн лабораториудыг сайжруулах төслүүд бас явж байгаа.

Тийм учраас улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй нийцэж байгаа гэж нэгдүгээрт ойлгож болно.

Хоёрдугаар асуудал. Ариун цэврийн байгууламжууд байгаа. Нүхэн жорлонгийн асуудал байгаа.

Би үүнийг Байнгын хороон дээр бараг гурван удаа мэдээлэл хийсэн.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ бол харьцангуй үр дүн гарч байгаа төсөл гэж ойлгож болно.

Энэ дээр 100 хувь би сайдын хувьд хариуцлага бүтээхэд бэлэн.

Анх мордохын хазгай эхэлсэн төсөл гэвэл мөн. Ямар ч зураг төсөлгүй тендерүүд зарлагдаж эхэлсэн учраас үүний тендерийг зогсоож байгаад дахиад бүх зураг, төслүүдийнх нь ажлууд хийгдээд одоо ингээд 4 ээлжээр энэ төсөл маань хэрэгжиж дуусаж байна.

Энэ жил ямар ч байсан энэ хичээлийн жилд бид 400 орчим сургууль, цэцэрлэг, дотуур байруудыг ашиглалтад өгчхөж байгаа.

Ирэх хавар гэхэд бид үндсэндээ 100 хувь Монгол Улсын хэмжээнд шинэ тооцоогоор 940 орчим сургууль, цэцэрлэг, дотуур байрны асуудлууд гарч ирж байгаа. Үүнийг ингээд бүрэн шийдвэрлэж чадна.

100 орчим тэрбум төгрөгийн юуг “Эрдэнэт” нийгмийн хариуцлагын хүрээнд манай Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд санаачилж энэ санхүүжилтийг тусгасан. Гэхдээ анхнаасаа зураг төсөлгүй зарласан учраас төсөвт өртөг нь маш их бага байсан.

Тийм учраас бид төсөвт өртөг, зураг, төслүүдээ дахиж хийгээд дахиад нийт 60-аад тэрбум төгрөгийн санхүүжилт хэрэгтэй болсон учраас бид Засгийн газрын хуралдаанд оруулж “Эрдэнэт” 100 дээрээ нэмээд 60 тэрбумын санхүүжилт буюу нийт 160 тэрбум төгрөгөөр нийт энэ 940 ариун цэврийн байгууламжуудыг хийгээд.

Бид ер нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 100 гэж орсон байгаа. Үүнийгээ бид 920 сургууль, цэцэрлэгүүдийг ирэх хавар сонгуулийн өмнө бүрэн хийж дуусгана. Үүнийг би хариуцлагатайгаар мэдэгдэж байна.

Гуравдугаар асуудал бол Шинжлэх Ухаан Технологийн Сангаас санхүүжүүлж байгаа судалгаанууд ер нь үйлдвэрлэлд нэвтэрч байгаа үр дүнгүүд ер нь юу байгаа юм. Одоо энэ Шинжлэх Ухаан Технологийн Сангаар санхүүжиж байгаа судалгааны хүрээлэнгүүдийн ажлын үр дүнг ер нь юугаар хэмжих вэ гэж байна.

Ажлын үр дүнг судалгааны үр дүнгээр хэмжинэ. Харьцангуй юу гэдэг юм, өнөөдөр энэ шинжлэх ухаанд зарж байгаа мөнгө. Бид чинь улсын төсвөөс бүх цалин, бүх урсгал зардлууд нь ороод 70-аад тэрбум төгрөг л зарж байгаа шүү дээ.

Шинжлэх Ухаан Технологийн Сангийн санхүүжилт сүүлийн 3 жил ерөөсөө өсөөгүй. 12-оос 13 тэрбум төгрөгт л байдаг нэг ийм л санхүүжилтийн сан байгаа юм.

Тэгээд харьцангуй 70-аад тэрбум төгрөгийн урсгал зардлаар бид шинжлэх ухаанд зарцуулж байгаа энэ мөнгө бол харьцангуй бага.

Бага мөнгөөр зарж байгаа судалгааны үр дүнг хэмжиж байгаа хэд хэдэн хэмжүүр байдаг.

Нэгдүгээрт, тэр судалгаа олон улс.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: 1 минут нэмж өгөөд гүйцээгээд хариулчихъя. Л.Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Олон улсын нэр хүндтэй судалгаанууд, сэтгүүлүүд дээр хэвлэгдэж байгаа энэ үзүүлэлтээр манай Шинжлэх Ухааны Академийн харьяа хүрээлэнгүүд маш их өндөр үзүүлэлтүүд гаргаж байгаа. Сүүлийн жилүүдэд.

Азидаа ч их өндөр хэмжээний үзүүлэлт гарч байгаа.

Одоо гагцхүү бид энэ бий болсон судалгааг яаж үйлдвэрлэлд нэвтрүүлж, яаж инновац болгож Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх вэ гэдэг дээр л санхүүжилтийн тогтолцоогоо бид бий болгох ёстой.

Тийм учраас шинжлэх ухаан, технологийн санхүүжилтийн тогтолцоо хэдийгээр бага мөнгө ч гэсэн бид үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо руу шилжүүлж, ямар ч байсан өрсөлдөөнт санхүүжилтүүдийг судалгаан дээр бий болгох, дундын лабораториудыг бий болгох, дундын лаборатори дээр хийсэн хамтын судалгаануудыг санхүүжүүлэх.

Тэр тусмаа их дээд сургуулиуд, шинжлэх ухааны хамтын ажиллагааг шинэ шатад гаргах чиглэлээр бид Шинжлэх Ухаан Технологийн Сангаас олгож байгаа санхүүжилтийн тогтолцоогоо шинэчилж бас тодорхой үр дүн гарч байгаа гэдгийг хэлье.

Өнгөрсөн хавар бид Байнгын хороон дээр одоо энэ шинжлэх ухаанаас олж байгаа ололтоо бас ярьсан.

Ер нь жил бүхэн улсын төсвийн өмнө Эдийн засгийн байнгын хороо, Инновац, манай Байнгын хороо хамтарч энэ үр дүнгүүдээ ярилцдаг болъё гэдэг нэг ийм шинэ ажлууд бас хийгдэж эхэлж байгаа гэдгийг танд хэлье.

Г.Мөнхцэцэг: Соёлын яамтай холбоотой. Орон нутгийн музейн засвартай холбоотой асуулт асуусан.

Соёлын яамнаас Ч.Номин сайд хаачсан юм? 1 номерын микрофон дээр Соёлын дэд сайд М.Батбаяр хариулт өгье.

М.Батбаяр: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг музейн хувьд Хувьсгалын музей, мөн түүнчлэн Сэлэнгэ аймгийн Орон нутгийн судлах музей хамтдаа нэг барилга Алтанбулаг сум дээр үйл ажиллагаа явуулж байгаа.

Ер нь аймгуудын музейг бид үе шаттайгаар шинэчлээд эхэлсэн. Яг одоогийн байдлаар 5, 6 аймгийн музей хөрөнгө оруулалтын ажлууд хийгдээд явж байгаа.

Түүнтэй холбоотойгоор Сэлэнгэ аймгийн музейг бие дааж байгуулах ажил эрэмбэлэгдээд явж байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь, Музейн тухай хуулиар музейн үзэл баримтлал, үзүүлэг дэглэлтийг музейн үүсгэн байгуулагч өөрөө байгуулах буюу аймгийн иргэдийн хурал зохион байгуулахаар хуульчилсан.

Үүнтэй холбоотойгоор бас зохион байгуулалтын ажлуудыг хийж эхэлсэн гэдгийг хэлье.

Дээр нь мэдээж тэр хүртэлх хугацааны энэ засвар шинэчлэлийн ажил Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиар орон нутгийн төсөвт засвар шинэчлэлтийн ажилтнууд хийгдээд явж байгаа.

Г.Мөнхцэцэг: Ч.Ундрам гишүүн нэмэлт тодруулга асуулт асуух уу? Ч.Ундрам гишүүний микрофоныг өгье.

Ч.Ундрам: М.Батбаяр сайд аа, та яг 2022 оны төсвийг ярьж байхад 100 сая төгрөгөөр энэ хувьсгалын музейг засуулна. Би танд амлаж байна гээд надад амласан байгаа.

Өнөөдөр шал өөр юм яриад бөөрөнхийлөөд, эрэмбэлэгдэж байна, барьж байна, орон нутгаас нь шийдүүлэх ёстой гээд худлаа ярьж байна шүү дээ. Худлаа ярьсан байна шүү дээ. Та.

Өмнө нь 2021 оны төсөвт суучихсан байсан. Танай Соёлын агентлагийн хариуцлагагүй байдлаас болоод төсөв, мөнгийг нь шилжүүлэхгүй, тэгээд ажил нь хийгдээгүй. Би 2022 оны төсөв дээр дахиад ярьсан. Та амлаж байна. Одоо яг засна гэсэн.

Одоо ингээд 2024 оны төсөв яриад бид сууж байна. Та тэгсэн чинь орон нутгаас нь үүнийг хийх ёстой. Музейн тухай хууль гээд ингээд өөрөөсөө булзааруулаад сууж байна.

Тэгээд өмнө нь одоо ингээд л жил болгон орж ирээд худлаа яриад байж болдог юм уу? Дараа жил нь бөөрөнхийлөөд л.

Г.Мөнхцэцэг: Ц.Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя. Тэр худлаа яриад байна. Дараалаад төсөв дээр суулгаад байгаа төсвийг өөр юманд зарцуулсан уу, яасан ийсэн, орхигдуулсан байна. Орон нутгаас ингээд шийднэ гээд өнөөдөр та тайлбар хэлж байна гээд Ч.Ундрам гишүүн зөв зүйтэй л асуулт тавиад байх шиг байх юм. Энэ дээр нь М.Батбаяр сайд та гүйцэд сайн хариулчхаач.

Ч.Номин сайд ер нь хаачсан юм бэ? М.Батбаяр сайд тэр асуултад нь гүйцээгээд хариул.

М.Батбаяр: Ч.Ундрам гишүүний асуулт нэмэлт тайлбар хэлье.

Тэгэхээр Алтанбулаг музей төсөвт тусгагдаагүй. Тухайн үед Ардын хувьсгалыг тэмдэглэн өнгөрүүлэх ойн төсвөөс зохион байгуулах ажлыг хийж, засварлах ажлыг зохион байгуулж байсан.

Үүнээс хойших хугацаанд ч гэсэн бид сайдын багцаас засварлахыг хичээсэн. Энэ талаар. Яг үнэндээ одоо бол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиар Соёлын сайдын багцаас орон нутагт засвар шинэчлэлт хийх боломжгүй байгаа. Боломжгүй байгаа.

Тийм учраас бид том асуудлыг нь шийдэх ёстой гэдэг ийм эрэмбийг хийгээд явж байгаа. Орон нутаг энэ талаар мэдээлэлтэй байгаа.

Г.Мөнхцэцэг: Ц.Мөнхцэцэг гишүүн асуултаа тавья.

Тэгэхээр 2021 онд манай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос ажлын хэсэг гараад миний бие ахлан Биеийн тамир, спортын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, тайлан дүгнэлт гаргаад засаг руу тогтоол оруулсан байгаа.

Энэ тогтоолд биеийн тамир, спортын салбарын он удаан жил баригдаад хөрөнгө оруулалт нь гацчихсан, тодорхой спортын заал, аймаг, дүүргүүд, хотын санхүүжилтийг яаралтай хийж барилгуудыг дуусгах чиглэлийг Засгийн газарт өгсөн байгаа.

Тэгээд Б.Жавхлан сайдаас асуулт байна.

Одоо 2024 оны төсөв дээр барилга, байгууламж дотор дүүргийн спорт цогцолбор гээд Баянзүрх дүүргийнх бол оруулсан байна. Энэ бараг арван хэдэн жил гацчихсан ийм хөрөнгө оруулалт, спортын цогцолбор байсан. Одоо ямар ч байсан явах нь байна. Налайх дүүрэг гээд явж байна.

Энэ дотор Сүхбаатар дүүргийн спорт цогцолборын төсөв хаачсан бэ? Тэр газрын маргаантай холбоотойгоор тодорхой асуудал үүссэн байсан. Одоо энэ төсвийг хэн хариуцах вэ гэдгийг Сангийн сайдаас асууя.

Хоёрдугаарт нь, спорт, олимпизм хариуцсан сайдад бас асуулт байгаа.

Ер нь сүүлийн жилүүдэд Монголын тамирчдын ёс зүй, допингтой холбоотой асуудал улс орны хэмжээнд хүртэл нэлээн ноцтой үр дагавар гарахуйц хэмжээнд байгаа.

Тийм учраас тамирчдын ёс зүйтэй уялдуулан шагналын бодлыг уях тал дээр Спорт, олимпизмын сайд ямар байр суурьтай байдаг вэ?

2024 оны төсөв дээр Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс авсан тамирчдынхаа шагнал урамшуулалд нийтдээ 2.1 тэрбум төгрөг өгөхөөр төсөвлөсөн байгаа.

Ер нь спортын салбарынхны дунд экспертийн судалгаа хийхэд шагнал урамшууллын бодлого их явцуу хүрээнд байдаг. Тодорхой тамирчид нь олимпоос медаль авсан ч гэсэн ёс зүйн болон бусад эрүүгийн гэмт хэргийн улмаас ял эдэлж байгаа ч гэсэн энэ шагналаа үргэлжлүүлэн аваад байгаа нь хойч үе болон нийгэм дэх спорт, олимпизмыг түгээн дэлгэрүүлэхэд сөрөг нөлөөтэй юм

биш үү гэдэг ийм шүүмжлэл нэлээн байгаа.

Тийм учраас тамирчдын шагналын бодлого дээр ямар байр суурь баримтлах вэ гээд.

Хоёрдугаарт, допингийн асуудалтай холбоотойгоор сая Азийн тоглолтод орсон боксын болон бас нэг спортын төрлийн 2 тамирчнаас допинг илрээд. Үүнтэй холбоотойгоор Спорт, олимпизмын сайд маань тухайн спортын холбоодод өгөх санхүүжилтийг зогсоож байгаа нь үнэхээр чухал зүйл болсон.

Ер нь Монголд ёс зүй, тамирчдын допингийн асуудлыг бид төрийн бодлого. Дээр нь төрөөс олгож байгаа спортын салбарын санхүүжилтэй нь уях ёстой гэдгийг дэм дэмжиж байна.

Тийм учраас энэ жишээг цаашид хатуу хадгалж, тамирчдын ёс зүй, шагналыг санхүүжилттэй уях шаардлагатай гэдгийг хэлмээр байна.

Боловсролын сайдад нэг асуулт байна. Ер нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр дээр нэг сайн заалт орсон байсан юм.

Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгож, судлаачдынхаа чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмнэ гэсэн байгаа.

Ингээд 2020 оноос хойш ер нь манай шинжлэх ухааны салбарын зардал хэр нэмэгдсэн бэ?

Ер нь шинжлэх ухаангүйгээр улс орон хөгжих, тэр дотроо хүн амын нөөц

багатай Монгол Улсын хувьд бид аль болох оюуны тархийг, эрдэмтдийнхээ хүч нөөцийг хөгжилд ашиглах ёстой.

Тийм учраас бид шинжлэх ухаанд мөнгө илүү зарах ёстой байдаг.

Тэгэхээр манай энэ салбарын шинжлэх ухаан, технологийн төсөв маань нэмэгдэж байна уу? Нэмэгдэж чадахгүй байна уу? Энэ дээр юу анхаарах ёстой вэ гэдгийг тодруулмаар байна.

Ер нь эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудын хамтарсан төвүүдийг нэмэгдүүлэх, эрдэмтдийнхээ инновацын бодлогыг төрийн хөгжил, улс орны хөгжилтэй ашиглах чиглэлээр бид илүү их төсвийг л зарцуулмаар байгаа юм.

Энэ тал дээр салбарын сайдын байр суурийг сонсьё.

Г.Мөнхцэцэг: Ц.Мөнхцэцэг нэлээн олон асуултууд тавьчихлаа.

Сангийн сайд дараагийн Байнгын хороон дээр танилцуулга хийх ёстой байгаа учраас. Дэд сайд байна уу? Дэд сайд С.Мөнгөнчимэг сайд.

Ж.Ганбат дарга Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулчихъя. 4 дүгээр микрофон дээр сууж байна уу? 4 дүгээр микрофон дээр.

Ж.Ганбат: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор. Энэ барилгын асуудал нь 2024 он биш, 2023 оны төсвөөс эхлээд зогсоосон юм байна.

Шалтгаан нь төсөвт өртөг их хэмжээгээр нэмэгдэж байгаа. Гүйцэтгэгч нь ажлаа гүйцэтгэхгүй байгаатай холбоотой гэрээ цуцлагдсан. Цаашид хэрхэн үргэлжлэх тодорхойгүй ийм байдлын улмаас үүнийг зогсоочихсон байгаа юм байна.

Тэгэхээр энэ асуудлыг нэг талд нь гаргаж байж. Ер нь энэ барилгыг цаашид яаж үргэлжлүүлэх вэ гэдэг асуудлыг нь захиалагч тал өөрөөр хэлбэл энэ асуудлын шийдлийг нь гаргаж байж үүнийг төсөв дээр хэрхэн тусгах гэдгийг нь дараагийн ээлжинд авч үзэхээс өөр аргагүй ийм нөхцөл байдал үүссэн юм байна.

Яах вэ, төсөвт өртөг нь 9.9, бараг 10 орчим тэрбум төгрөг гээд яамныхан тайлбарлаж байгаагаар.

Харьяаллын хувьд үүнийг бас яах вэ гэдэг асуудал захиалагч салбарын яам нь ярьж байгаа. Яам нь энэ дээр нэмж тайлбар хэлэх нь зүй зөв байх.

Нэг бол МУИС-д шилжүүлэх гэдэг бас ийм асуудал яригдаж байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлуудаа цэгцэлчхээд үүний дараа бид төсөв дээр тусгаж үүнийг дуусгах нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг Сангийн яам баримталсан байгаа.

Бас газрын маргааны асуудал бас энэ дээр байгаад байгаа юм байна.

Тэгэхгүй бол бид төсөв дээр энэ асуудлыг нь цэгцлэхгүйгээр мөнгийг нь тавьчихлаар хэрэгждэггүй. Тэгээд нөгөө мөнгө нь жилийн эцэс болохоор хураагддаг иймэрхүү асуудал байгаа учраас бид аль болох төсөв дээр тусгагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах

зорилгоор эхлээд энэ асуудлуудыг шийдчихээд дараа нь төсөв дээр тусгая гэдэг ийм байр суурийг Сангийн яам баримталсан.

Г.Мөнхцэцэг: Б.Бат-Эрдэнэ сайд. Спортын сайдаас хэд хэдэн асуулт асуусан.

2024 оны төсөвт суусан тэр тамирчдын шагнал, урамшуулалтай холбоотой асуудлыг тавилаа.

Тэр допингийн асуудлаар мөн асуултууд тавьсан. Энэ асуултад Б.Бат-Эрдэнэ сайд хариулах уу?

Б.Бат-Эрдэнэ: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Тамирчдын ёс зүй, сахилга, хариуцлагын асуудал хамгийн тэргүүн ээлжид тавигдаж байгаа. Тамирчид төдийгүй дасгалжуулагч, шүүгчид, спортын зүтгэлтнүүд, спортын салбарын ажиллагсад, багш, дасгалжуулагчид бүгдэд хамаатай ийм асуудал.

Энэ ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой асуудлыг тогтоож чадаагүйтэй холбоотойгоор бид 2008 онд олимпын олон аваргуудыг төрүүлсэн.

Тэгээд энэ асуудал дээрээ ер нь үеийн үед л анхаарал тавьдаггүй. Хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгодоггүй. Ёс зүйн зөвлөлүүдээ холбоод байгуулдаггүй.

Тэгээд ийм асуудлууд явагдаж ирсэн гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Тийм ч учраас Та бүхэн маань Г.Дамдинням гишүүн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороог

ахалж ажиллаж байхдаа ажлын хэсэг гарсан.

Ажлын хэсгийг Ц.Мөнхцэцэг гишүүн ахалж байсан. Тэгээд энэ дагуу ажилласан. Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн тогтоол баталсан.

Энэ тогтоолтой нийцүүлээд тамирчдын шагнал, урамшилтай холбоотой асуудлыг журмаар зохицуулж байгаа.

Энд яг таны тавьж байгаа шаардлагын дагуу тамирчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбож шагнал урамшлыг олгоно.

Ёс зүй, сахилга хариуцлага алдсан тамирчид, дасгалжуулагчдад шагнал, урамшууллыг зогсоохоор журамлаж өгсөн байгаа.

Түүнчлэн нийгмийн хариуцлагын хүрээнд, нийгмийн сайн сайхны тулд тодорхой ажил зохион байгуулдаг, оролцдог. Үүнийг нь Биеийн тамир, спортын улсын хороо, биеийн тамир спортын энэ төрийн захиргааны байгууллага тамирчидтай тодорхой гэрээгээр зохицуулж ингэж ажиллаж байгаа шүү гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Тамирчдын допингтой холбоотой асуудал. Энэ бол олон жил ужгирсан ийм асуудал.

Намайг ажил авахад олон улсын **WADA** /World Anti-Doping Agency/ байгууллагаас допингийн зэрэг үндэсний дүрмээ 10 сарын 27-ны наана батлах ийм шаардлага гарчихсан.

Маш их зөрчилтэй, ингээд гацаад зогсчихсон байсан асуудлуудыг тал талын оролцоотой уулзалт, ойлголцолд

хүрч ингээд Засгийн газар 10 сарын 19-нд хугацаандаа үндэсний дүрмээ баталсан.

WADA-гаас Засгийн газрын хүлээх үүрэг биелсэн гэж хэлж болно.

Түүнчлэн Биеийн тамир, спортын улсын хороо манайд байгуулахдаа олон жил энэ санхүүжилтийн маргаан, аудитын дүгнэлт, тайлантай холбоотой ийм маргаан ужгирсан.

Үүнтэй холбоотойгоор 2020 оны Токиогийн олимп, 2021 оны Бээжингийн олимпиадад тамирчдын шинжилгээ авсан энэ төлбөр өр үүсчихсэн.

Энд **WADA**-гаас бас энэ оны 8 сарын 22-ны наана энэ төлбөрийг барагдуулах ийм шаардлага ирсэн.

Ингээд 8 сарын 16-нд ирсэн **WADA**-гийн 2 төлөөлөлтэй зөвшөөрөл авч байж энэ өр төлбөрийн асуудлыг Солонгосын лаборатори руу шууд шилжүүлсэн.

22-ны өмнө мэйлээр **WADA**-д хүргүүлсэн. Хүлээж авсан. Энэ асуудал байхгүй. Нэг үгээр хэлэх юм бол Засгийн газар үүргээ бүрэн хэмжээнд биелүүлж ирсэн.

Монгол Улсын Засгийн газар, Их Хурал энэ 7 сард хийсэн төсвийн тодотголоороо энэ өр төлбөртэй холбоотой, 2023 оны санхүүжилттэй холбоотой бүх асуудлыг нь шийдэж өгсөн явж байгаа.

Тэр санхүүжилтийг зогсоох шийдвэрийг бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн дагуу спортын төрийн захиргааны байгууллага буюу Биеийн тамир, спортын Улсын хорооны дарга

О.Баттулга Боксын холбоонд албан шаардлага хүргүүлсэн.

Энэ улсууддаа хариуцлага тооц оо гэж.

Г.Мөнхцэцэг: Б.Бат-Эрдэнэ сайдын микрофоныг нэмж өгье. Асуултад нэмээд гүйцээгээд хариулчихъя.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр Биеийн тамир, спортын Улсын хорооны дарга О.Баттулгын явуулсан, Засгийн газрын баталсан журмын дагуу явуулсан шаардлагад Боксын холбоо хариу ирүүлсэн.

Допингтой холбоотой тамирчнаа шигшээ багаас хассан. Холбогдох дасгалжуулагч, эмч, холбогдох хүмүүст ийм арга хэмжээ авлаа гэдэг бичиг цаасаа ирүүлсэн.

Харамсалтай нь энэ зориуд байна уу, эсвэл ямар шалтгаантай байна вэ. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан сайд энэ санхүүжилтийг зогсоосон мэтээр олон нийтэд төөрөгдүүлсэн мэдэгдэл Боксын холбооноос гаргасан.

Ийм хариуцлагагүй байж болохгүй. Өөрснөө шаардлагыг хүлээж аваад, хариуцлагаа тооцоод албан тоотой ирүүлчихсэн байдаг. Нөгөө талдаа болохоор ийм шаардлага гаргаад ингээд байж байдаг.

Энэ бол сахилга хариуцлагагүй, ёс зүйгүй байгаа.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Ц.Мөнхцэцэг гишүүн нэмж тодруулах уу? Болчихсон уу?

Боловсролын яамтай
холбоотойгоор, Шинжлэх Ухааны
Академитай холбоотойгоор асуулт
асуусан.

Түүнээс Б.Бат-Эрдэнэ сайдын
микрофон уг нь ч минут нь болчихсон
байдаг.

Б.Бат-Эрдэнэ сайдын микрофоныг
нэмж өгье. 1 минутад гүйцээгээд
хариулчих.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр
ойлголт оог нэгтгэх хэрэгтэй. Юу байна вэ
гэхээр, саяын тэр шагнал урамшил олгох
журам Байнгын хорооноос өгсөн үүрэг,
чиглэлийн дагуу бид ёс зүй, сахилга
хариуцлагатай нь холбож өгч байгаа.

Тийм учраас эрүүгийн хариуцлага
хүлээсэн хүнд тэр шагнал урамшил огт
олгогдохгүй шүү дээ.

Тийм учраас энд нэг ойлголт
явагдаад байгаа юм нь эрүүгийн
хариуцлага хүлээчихсэн хүмүүсийн
шагнал урамшлынх нь асуудлыг олгоод
байгаа юм шиг ийм ойлголт яваад байна
шүү.

Тийм учраас шүүхийн тогтоолоор
эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн
цагаас нь эхэлж шагнал урамшлыг олгох
тухай асуудал яригдах болохоос биш энэ
эрүүгийн хариуцлага хүлээчихсэн байгаа
хүмүүст огт олгохгүй байгаа.

Ёс зүйн зөрчил гаргасан тамирчин,
дасгалжуулагч, холбоонд энэ шагналыг
олгохгүй байх тухай ийм Засгийн газрын
журамд тодорхой зачихсан байгаа шүү.

Энэ бол Их Хурал Та бүхний
тогтоолоор өгсөн үүрэг, чиглэл биелж
байгаа гэж ойлгоорой гэдгийг хэлье.

Г.Мөнхцэцэг: Л.Энх-Амгалан
сайд. Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад
хариулъя.

Шинжлэх ухааны салбартай
холбоотой тодорхой асуултауд тавьсан.

Л.Энх-Амгалан: Ч.Ундрам
гишүүн, Ц.Мөнхцэцэг гишүүн хоёрын
асуултад нэгтгээд хариулчихъя.

Ер нь манай Засгийн газрын 4
жилийн мөрийн хөтөлбөрийн
биелэгдэхгүй үлдэж байгаа цөөхөн
заалтуудын нэг нь энэ шинжлэх ухаанд
зарцуулах төсвийн зардлыг 4 дахин
нэмэгдүүлнэ гэсэн энэ заалт л үлдэж
байгаа юм билээ.

Тэр тусмаа Боловсрол, шинжлэх
ухааны салбарт тавьсан зорилтуудаас
зөвхөн энэ зорилт нь биелэхгүй үлдэж
байгаа юм.

Хэрэв энэ зорилтыг бид биелүүлнэ
гэх юм бол жилд судалгаа, шинжилгээн
дээр зарцуулж байгаа 12 тэрбумаа 48
тэрбум төгрөг л болох ёстой шүү дээ.
Хамгийн багадаа.

Тэгээд сүүлийн 4 жилийг тасалж
асуух шиг боллоо. Ерөөсөө шинжлэх
ухаанд зарцуулж байгаа мөнгийг бид нэг
ч төгрөгөөр нэмээгүй. Нэг ч төгрөг
нэмээгүй.

Яах вэ, КОВИД гээд бидний
тооцоогүй хүчин зүйл үүссэн байх.
Гэхдээ КОВИД-д хамгийн их хувь нэмэр
оруулсан салбар бол шинжлэх ухааны
салбар шүү. Өөрийн оношлууруудыг
хийлээ. Анагаахын шинжлэх ухааны
хүрээлэн дээр эрдэмтдийн хүчээр Монгол
Улс 40 мянган хүний амь насны ийм
бодитой эрсдэл байсан.

Энэ эрсдлийг давж туулсан нь шинжлэх ухаан, энэ эрдэмтдийн л гавьяа гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр бид шинжлэх ухаанд зарж байгаа дотоодын нийт бүтээгдэхүүнийг 1.0 хувьд хүргэхэд эдийн засгийн өсөлтийг 0.7 хувьд хүргэнэ.

Ингээд бусад улсуудтай харьцуулахад. Бусад гэдэг нь өөрийнхөө улсуудтай арай жаахан ойролцоо, хөгжлийн түвшин ойролцоо улсуудтай харьцуулахад бид 10-аас 15 дахин бага санхүүжилт өнөөдөр зарж байгаа байхгүй юу.

Тэгээд эндээс бид үр дүн нэхээд байна гэдэг их хүндрэлтэй шүү дээ. Одоо сүүлийн 7, 8 жилийн нэгдсэн дүнгээр авч үзэхэд энэ Шинжлэх Ухаан Технологийн Сангаас 170-аас 180 орчим тэрбум төгрөгийг 3600 орчим судалгаанд зарцуулсан байдаг юм.

Тэгээд нэг судалгаанд зарцуулсан дундаж санхүүжилт 20 сая төгрөг л байхгүй юу.

Одоо Ж.Чинбүрэн доктор, Ж.Чинбүрэн гишүүн сууж байна. 20 сая төгрөгөөр бид судалгаа санхүүжүүлээд тэгээд тэндээс үр дүн хүлээнэ. Тэндээс үр дүнг нь гаргаад инновац болгоно. Инновацыг бид эдийн засаг, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ гэдэг хүндрэлтэй зүйл шүү дээ.

Манай Д.Рэгдэл академичийн нэг үг сүүлийн үед их таалагдаад байгаа юм.

“Багахан мөнгөөр багагүй үр дүн гаргадаг салбар” гэж. Энэ бол шинжлэх ухааны салбар.

Ж.Чинбүрэн гишүүн байхдаа хийсэн **“Элэг шилжүүлэн суулгах”** судалгааг Шинжлэх Ухаан Технологийн Сан санхүүжүүлсэн. Тийм ээ. Ж.Чинбүрэн гишүүн ээ.

Өнөөдөр хэдэн зуун хүний амь насыг, хэдэн зуун хүний хилийн чанадад зарцуулах мөнгийг өнөөдөр бид хэмнэж чадаж байгаа. Энэ бол шинжлэх ухааны үр дүн.

“Дархан-144” гэдэг сортыг бий болгож чадсанаараа жилд бид **10 тэрбум** төгрөгийн нэмүү өртөг, алдах байсан ургацаа хэмнэж чадаж байна. Жилд 10 тэрбум төгрөг.

Сүүлийн **6 жил 60 тэрбум** төгрөг ганцхан энэ сортыг бий болгосноор хөдөө аж ахуйн салбар ийм нэмүү өртгүүдийг бий болгож чадаж байгаа юм.

Тэгэхээр одоо ингээд маш бага мөнгөөр хийсэн судалгаа, шинжилгээ эргээд эдийн засагтаа ийм өндөр их үр дүн өгдөг юм байна гэдгийг бид харах ёстой.

Одоо удахгүй бид Шинжлэх ухаан, технологийнхоо хуулийг өргөн барих гэж байна.

Энэ Шинжлэх ухаан, технологийн хуулиар бид ерөөсөө Монгол Улсад цаашдаа шинжлэх ухаанаа яаж хөгжүүлэх юм бэ, ямар тогтолцоогоор хөгжүүлэх юм бэ, санхүүжилтийн тогтолцоо нь юу байх юм бэ, хүний нөөц бэлтгэх тогтолцоонууд нь юу байх юм бэ, инновацуудаа үйлдвэрлэлд нэвтрүүлдэг эдийн засгийн хөшүүргүүд нь юу байх юм бэ гэдэг энэ асуудлуудыг ер нь тогтолцооны шинэчлэл хийж байж л бид шинэчлэл гаргахгүй зүгээр нэг улсын

төсвийн ганцхан эх үүсвэр хараад тэгээд эндээ шинжлэх ухааныг хөгжүүлж байна гэж бие биеийгээ хуурч сууж болохгүй л дээ. Тийм ээ.

Тэгэхээр удахгүй Улсын Их Хуралд өргөн баригдах гэж байгаа энэ Шинжлэх ухаан, технологийн хуулийг дэмжиж. Тийм ээ. Цаашдаа энэ хууль батлагдаж гарснаар Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбарыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчнуудыг хийх.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Л.Энх-Амгалан сайд баярлалаа. Б.Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая.

Сая аудитын дүгнэлтийг танилцуулахад төсвийн зорилго хангагдах эсэхийг дүгнэх боломжгүй гэдэг дүгнэлтийг аудит гаргачихлаа л даа.

Өнгөрсөн жил Улсын Их Хуралд Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн барихдаа төсвийг олон нийтээрээ хэлэлцүүлдэг байх, төсөв батлагдсаны дараа төсөлд тендерийг зарладаг байх, гүйцэтгэл дээр нь хяналт тавих тэр боломжийг бий болгох олон зорилгын хүрээнд уг нь энэ төсвийн хуулийг шинэчилсэн.

Энэ зорилгоор хуулийг өргөн барьж батлуулсан байгаа. Өөрөөр хэлэх юм бол тойргийн төсөв биш улсын төсвөөр хардаг байя гэдэг ийм зорилгыг ч гэсэн хуулийн үзэл баримтлалд бас тусгагдсан байсныг Та бүхэн сайн санаж байгаа байх.

Тэгээд төсөв маань яг амсуулаад тавьдаг, амсуулаад тавьдаг ийм байдлаас

шалтгаалан төсөв нэмэгдэх энэ байдал өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байгаа.

2020 онд Улсын Их Хурлын гишүүн болсон даруйдаа энэ үгийг хэлээд үр дүнг нь гаргая гэсэн боловчиг 4 жилийн хугацаа өнгөрчихлөө. Зөвхөн жишээ хэлэхэд манай 32 дугаар хороон дээр баригдаж байгаа “Фүжи Алтай” гээд нэг гүйцэтгэгч компанитай **640 хүүхдийн сургуулийн барилга** өнөөдрийг хүртэл баригдаагүй.

Тэгээд өнөөдрийн төсөв харсан чинь энэ жил санхүүжих дүн нь 268.8 сая төгрөг тавигдсан байх юм. Өнгөрсөн төсөв дээр 374 сая төгрөг тавигдаад. Нөгөө хариуцлагагүй компани нь ажлаа хийж чадахгүй байгаад төсвөө татуулчихсан.

Сайд, бид нар бас очиж уулзаад л, компанид нь хариуцлага тавиад л, үүрэг өгөөд л уг нь 10 сарын 15-н гэхэд хүлээлгэж өгөөрэй гэсэн боловч энэ компани ямар ч ажил гүйцэтгээ гээгүй.

Тэгээд энэ компанийг хар жагсаалтад оруулж өгөөч ээ гэдэг хүсэлтээ би бас Боловсролын сайдад тавьчихсан байгаа.

Энэ мэтээр дутуу дутуу, нэг амсуулаад амсуулаад. Сайдын хэлснээр. Тийм ээ. Тавьсан төсөв маань улам үрэлгэн болоод л, улам нэмэгдээд байгаа дээр Сангийн яам ямар дүгнэлт хийдэг юм бэ?

Уг нь улс нэг төсөвтэй байя гэдэг үүднээсээ аливаа ажлын гүйцэтгэлийг хангаж өгөхийн тулд тодорхой хэмжээний төсвийг хангалттай тавьж өгье гэдэг санал Төсвийн тухай хуулиар батлагдсан байгаа шүү дээ.

Хоёрдугаарт нь, 2019 онд батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулиараа бид 2020 оны 01 сарын 01-нээс сургуулийн хүүхдүүдийн хоол үйлдвэрлэлийг шинэ шатанд гаргах, төсөв мөнгийг нь нэмэгдүүлэх. Үйлдвэрлэгчид нь гэрээгээр биш өөрсдөө гуанзтай байх энэ боломжуудыг нээж өгсөн.

КОВИД-ын хуулиар хууль хэрэгжихгүй байсан. Хойшилсон. Өнөөдөр ер нь ямар шатанд явж байгаа вэ гэдгээ асууя.

Гуравдугаарт нь, Соёлын сайдаас асуумаар байна. Би М.Батбаяр сайдыг түрүүний Ч.Ундрам гишүүний хэлсэнчлэн худлаа ярьдаг үгэнд нь автсаар байгаад 4 жил өнгөрлөө.

“Хүүхдийн номын сан”, “Хүүхэлдэйн театр”-ын барилга маань өнөөдрийг хүртэл байхгүй.

Би сая төсвөөс юм хайгаад олсонгүй. Уг нь хүүхэддээ чиглэсэн соёлын бодлогыг бид өндөр хэмжээнд тавих юм бол монгол хүний, ирээдүй монгол хүний зөв төлөвшлийн талаар бид ам бардам ярих эрх үүснэ.

Өнөөдрийг хүртэл энэ ажил маань яагаад хийгдэхгүй байгаа юм бэ гэдэг зүйлийг асууя.

“Үндэсний урлагийн их театр” Хятадын Засгийн газрын шууд хөрөнгө оруулалтаар 800 сая юанийн хөрөнгөөр баригдахаар болсон гэдэг мэдээлэл байгаа. Бас л гагцхисан. 4 жил боллоо.

Ер нь 800 сая нь ороод 2 жил боллоо. Яачихав аа.

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр” маань сая 60 жилийн ойгоо тэмдэглэсэн. Бараг худалч хүнд 60 жилд ганц хөшигтэйгөө л байгаад байгаа. Энэ дээр төсөв хайгаад олсонгүй ээ.

Бид урлагаар дамжуулан иргэдээ, залуучуудаа хүмүүжүүлэх тэр ажил маань яг Соёлын яамтай болсон энэ цаг мөчөөсөө эхлээд уг нь өндөр шатанд гарна гэсэн боловч өнөөдрийг хүртэл байдаг байрандаа байсан хэвээрээ байна.

“Улсын хүүхэд, залуучуудын театр” босож байгаа. Гүйцэтгэгч компани нь удаашралтай байгаа. Би хэдэн жил тойргийнхоо сонгогчдод худлаа хэлж байна. Театр маань ашиглалтад орох гэж байгаа, театр маань ашиглалтад орох гэж байгаа. Гүйцэтгэгч компани ажлаа гүйцэтгэдэггүй.

Энэ дээрээ хяналт тавиад ажлаа түргэтгэх тал дээр Соёлын яам арга хэмжээ авч болдоггүй юм уу? Энэ дээр арга хэмжээ авч өгөөч ээ.

“Үндэсний номын сан” байна. Бас байхгүй.

Энэ дээр нэг гоё төсөв байна. Консерватурын шинэ байр. Газар нь асуудалтай байсан. Газрын асуудлыг нь бүрэн шийдсэн үү. Бас л хуулийн шатанд очсон гээд энэ асуудал гагцхисан юм биш биз дээ. Энэ дээр тайлбар өгөөч ээ?

Г.Мөнхцэцэг: Хэд хэдэн салбараас асуулт асуулаа. Эхлээд Сангийн яам нэгдүгээр асуултад нь хариулаад явчихъя.

Ж.Ганбат даргын микрофон. 4 дүгээр микрофон дээр.

Ж.Ганбат: Б.Жаргалмаа
гишүүний асуултад хариулья.

Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд баригдаж байгаа 640 хүүхдийн сургуулийн асуудал 2018 оноос 2024 онд хэрэгжих хугацаатай, “Фүжи Алтай” гээд компани үүнийг хэрэгжиж байгаа гээд.

2018-2022 онд нийтдээ 4.1 тэрбум төгрөгийг нь авчихсан байгаа юм.

Ажлын гүйцэтгэл нь бол 93.9 хувьтай гээд. Тэгээд энэ нь дуусдаггүй.

2024 оны төсөвт өртгийг нь тендерийн хэмнэлтээр 46.7 сая төгрөгөө бууруулаад 4.4 тэрбум төгрөгөөрөө, санхүүжих дүнг нь 268-аар гээд яг энэ хуулийнх нь хугацаа нь ингэчихсэн.

Ер нь Сангийн яамны байр суурь бол төсөв дээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг үр дүнтэй болго гэдэг дээр яг Төсвийн хуулийн санал аваад эхлэхээс эхлээд бүх процесс эхнээс нь бид энэ дээр дүн шинжилгээ хийх, анхаарах ёстой болчихоод байгаа юм.

Зурагтай, төсөвтэй бэлэн төслийг төсөв дээр үүнийг тусгах ёстой.

Дараа нь, төсөв батлагдсаны дараа тендерээ зарлах ёстой. Төсөв батлагдангуут дараа жилийн төсвийн жил хэрэгжихээс өмнө 11 сарын 15-нд төсөв батлагдангуут тендер зарлах ёстой шүү дээ.

Эндээс эхлээд л бид энэ дээр хариуцлагатай байхгүй бол ямар нэгэн төсвийн хөрөнгөөр тендер авчхаад тэрийгээ дуусгадаггүй. Тэгээд энэ дээр хариуцлагагүй ханддаг, төсөвт өртгөө нэмдэг ийм түгээмэл юмнууд байгаа юм.

Тэгэхээр Сангийн яам энэ дээр төсвийн санал авахыг нь аль болох цахимжуулчихсан, тусгай шаардлагуудыг нь биелүүлэх юм бол энэ яг төсвийн программ дээр энэ саналууд нь орж ирээд энэ дагуу тусгах, аль болох хяналтыг нь сайжруулчихаад байгаа юм.

Нөгөө талдаа гүйцэтгэгч компаниуд дээр бид хар жагсаалтад оруулах асуудал дээр одоо яг яригдаад Засгийн газар дээр ч удаа дараа яригдсан.

Үүнийг бид одоо зарлана. Энэ компаниуд дахин сонгон шалгаруулалт оруулахгүй гэдэг ийм байдлаар.

Нөгөө талдаа захиалагч нарын бас хариуцлагын асуудал байгаа. Хяналтаа тавих ёстой. Хугацаандаа дуусгаж чадахгүй бол үүнийг зогсоодог. Яаралтай дараагийн арга хэмжээнүүдийг авдаг асуудлуудыг шийдэхгүй бол энэ бол маш олон жил яригдаж байгаа.

Үнэхээр хугацааны хувьд бид янз бүрийн аргаар хугацааг нь наашлуулж үзсэн, цаашлуулж үзсэн. Боломжийг зөндөө олгосон. Гэхдээ энэ бол компаниудын санхүүгийн боломж, чадавх, чадваргүй компаниуд тендерт сонгон шалгаруулж байгаагийн гол шалтгаан шүү дээ.

Тэгэхээр энэ дээр тендерийг зарлах, зохион байгуулахад бас энэ талыг нь анхаарах. Энэ дээр хариуцлагын асуудлаа давхар авч явахгүй бол энэ асуудлууд удаа дараа гарч байгаа юм.

Нөгөө талд төсвийн хуулийн шинэчлэлийн дагуу олон нийтийн саналыг энэ 2024 оны төсөл дээр авсан.

Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд 21 аймагт ажиллаад иргэдийн саналын дагуу тусгасан.

Гэхдээ төсвийн хууль дээр нэг тусгачихсан бол амсуулах байдлаар биш яг хэрэгжих хугацаандаа тэнцүү байдлаар санхүүжих дүнг нь хуваарилах байдлаар ингэж тусгасан. Үүний үр дүнг бид. Яах вэ, энэ жилээс өмнөх олон жил царцаж байсан барилгууд ашиглалтад оруулахад ахиц гарч байгаа юмнууд байна л даа.

Үүнийгээ улам сайжруулах ийм шаардлагууд бий.

Г.Мөнхцэцэг: Хүүхдийн хоолны зардалтай холбоотойгоор асуулт асуусан. Үүнийг Л.Энх-Амгалан сайд хариулья.

Л.Энх-Амгалан: Энэ тендерийн гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг ер нь Б.Жаргалмаа гишүүн ээ, тогтолцооны хувьд нь бид дахиж хармаар юм байна.

Яагаад гэвэл үндсэндээ бүх хөрөнгө оруулалтын чинь бараг 40, 50 хувь нь боловсролын салбарт явдаг учраас яг гол захиалагч бол Боловсрол, шинжлэх ухааны яам бас байгаа юм.

Тэгээд энэ яг батлагдсан төсвийнхөө дагуу энэ гүйцэтгэл яг цаг хугацаандаа хийгдэж чадаж байна уу, хяналт нь хийгдэж чадаж байна уу гэдэг асуудлаа тогтолцооны хувьд гэдэг нь энэ Барилгын хөгжлийн төвийн тогтолцоог.

Одоо Сангийн яамныхан ч гэсэн надтай санал нэг байгаа болов уу гэж бодож байна. Ж.Ганбат дарга аа.

Монгол Улсад байгаа Барилгын хөгжлийн төвийн тогтолцоог бид эргэж харж задлах асуудал ярихгүй бол. Бүх

барилгын хяналт зөвхөн нэг агентлаг дээр.

Энэ чинь улсын хэмжээнд бараг мянга гаруй объектуудын хяналт явдаг гэж ойлгосон шүү дээ.

Үндсэндээ яг газар дээрээ хяналтууд явагдаж чадахгүй. Эндээс болж цаг хугацаа алддаг нэг ийм зовлон байна.

Хоёрдугаар асуудал, энэ зураг, төсөвгүй тендер зарлагддаг. Зураг, төсөвгүй төсөв батлагддаг. Нийслэлд газаргүй төсөв батлагддаг. Үүнээс болж их олон ажлууд хойшилж байгаа ийм зовлонгууд бас байгаа.

Нөгөө талаасаа сая Ж.Ганбат даргын хэлж байгаа захиалагчийн буруутай шийдвэрээр. Улсын төсөвт нь өөрөө 320 хүүхдийн сургууль гэж зарлагдаад төсөв тавигдсан байдаг. Тендер зарлахдаа дур мэдээд 640-өөр нийслэлийнхэн гэдэг юм уу, аймгийнхан гэдэг юм уу төсөвт өртөг нь өөрчлөгдөөд явдаг нэг ийм зовлон байгаа.

Энэ бас цаанаа нэг тийм заль, технологи болчихсон юм болов уу гэж би бодоод байгаа юм. Яг гүйцэтгэгч, тэр магадлан хийдэг гээд ингээд бүр технологийн гинжин хэлхээ, тендерийн хонгил гэж хэлж болохоор.

Сүүлийн үеүдэд би “Энэ угжны хур хурга шиг хэдэн компаниуд бий болчихсон байна” гэж хэлснээсээ болж нэлээн муу хэлүүлж, гүтгүүлж байх шиг байна л даа. Гэхдээ би муу хэлүүлэх яах вэ.

Яг үнэхээр улсын төсвөөр маш хямд үнэтэй тендер авдаг. Зориудаар, санаатайгаар. Тендерт ялдаг. Маш хямд

үнэтэй. Тэгээд жил бүхэн тэр төсвөө магадлан хийлгээд нэмэгдүүлээд явж байна.

Одоо 2012 оноос эхэлсэн зарим цэцэрлэг, сургууль дуусахгүй явж байсан юу байна шүү дээ. Тэгээд санаатайгаар.

Тэгээд бүр сургуулийн гүйцэтгэлийн 95, 96 хувьтай гүйцэтгээд. Одоо **5 дугаар сургууль**. Одоо тэр **32 дугаар сургууль**. Түгжээд алга болчихдог. Тэгээд төсвөөр төрийг дарамталдаг ийм болчихсон байгаа байхгүй юу. Бүр ийм түвшинд хүрчихсэн байгаа байхгүй юу. Энэ технологи. **“Тендерийн хулгайн технологи”**.

Тэгэхээр бид үүнийг таслан зогсоохын тулд сая энэ Тендерийн хууль шинэчлэгдлээ.

Тэгээд цаашдаа захиалагч, хяналтын тогтолцоонуудаа шинэ шатанд гаргаж байж энэ дээр тодорхой өөрчлөлт, шинэчлэлтүүд гарах болов уу гэж бодож байгаа.

Хүүхдийн хоолны тухайд би П.Анужин гишүүн шиг л ажиллаасай гэж бүх гишүүнийг бодож байгаа шүү дээ. Тийм ээ.

Яг өөрийнхөө хариуцсан дүүргүүд дээр бүх сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж. Тийм ээ. Б.Жаргалмаа гишүүн бас энэ жилээс.

Ингээд Сонгинохайрхан дүүрэг гэдэг яг үлгэр жишээ дүүрэг болоод төрийн өмчийн бүх сургууль, цэцэрлэгүүд өөрийн гал тогоотой. Тэгэхдээ олон улсын шаардлагад тэнцэхүйц хэмжээний ийм гал тогоотой болчихож байгаа юм.

Өнөөдөр нийслэлийн хэмжээнд 156 сургуулиудын 50 хувь нь буюу 80 сургууль түрээсийн гал тогоотой байна гэсэн мэдээлэл байгаа.

Улсын хэмжээнд яах вэ, 680-аад сургуулиас үндсэндээ түрээсийн гал тогоотой сургуулиуд бол 100 орчим сургуулиуд түрээсийн гал тогоотой.

Тэгэхээр бид энэ түрээсийн гал тогоог л халж байж хүүхдийн 1500 төгрөг. 1500 төгрөг бол материал худалдаж авч байгаа мөнгө шүү дээ. Материал худалдаж авч байгаа. Тогоочийн, хоол зүйчийн, хоол бэлдэж байгаа тэр цахилгаан дулааны зардлууд урсгал зардалдаа явж байгаа юм.

Тэгэхээр тогтолцоогоо эргэж харах нь зүйтэй юм байна гэж бид харж байгаа.

Одоо бид **КОЙКА**-гаар 10 нийслэлийн сургуулийн гал тогоо шинэчлэх төслүүд явж байна.

Тэгээд цаашдаа ер нь энэ нийслэлийн сургуулийн хоол.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Нэмэлт 1 минут өгье. 1 минутад гүйцээгээд хариулчихъя. Л.Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Нийслэл дээр байгаа төрийн өмчит сургуулиудын гал тогооны асуудлууд, хоол үйлдвэрлэлийн асуудлууд, аймгийн төв дээр байгаа хоол үйлдвэрлэлийн асуудлууд, сумын төв дээр байгаа хоол үйлдвэрлэлийн асуудал гурван тусдаа юм билээ. Гурван тусдаа.

Харьцангуй сумын төв, аймгийн төвүүд их боломжтой байдаг. Одоо өөрийнхөө сургууль дээр тэр гал тогоогоо

хөгжүүлээд, тэгээд хоол үйлдвэрлэлийг бол жинхэнэ утгаар нь хийгээд байж байгаа бололцоонууд гарч байгаа. Одоо хоол зүйчүүдээ бид хангачихвал.

Нийслэл дээр байгаа энэ 4 төрийн өмчит компанийн тогтолцооны асуудал байна. Цэцэрлэг, сургуулиудыг түүхий эдээр хангадаг. Бас л дунд нь цавчаа хийдэг л компаниуд шүү дээ.

Тэгээд одоо үүнийг цаашдаа бид нийслэлийн дүүргүүдэд өөрийн гал тогоог хийхэд хүндрэлтэй байгаа сургуулиуд дээр дундын гал тогоонууд хийх загваруудыг бид Солонгосуудтай хамтарч хийж байна.

Тэгээд ер нь сургууль дээр анхан шатын түүхий эдийн боловсруулалт хийдэггүй, хагас боловсруулсан бүтээгдэхүүнүүдийг авч бид.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Соёлын яамтай холбоотой хэд хэдэн асуулт тавьсан.

Соёлын сайд ер нь хаачсан юм бэ? Улсын төсөв хэлэлцэж байхад төсвийн захиран зарцуулагч нар бүгд бүрэлдэхүүнээрээ байж байх ийм үүрэгтэй шүү дээ.

Гишүүд нэхээд байна. Хаачсаныг нь хариул гэж зарим нэг гишүүдээс санал гараад байна. Эхлээд тэр сайдаа хаачсаныгаа хариул. Асуултад нь хариул.

Тэгээд дараа нь Б.Жаргалмаа гишүүний асуусан хэд хэдэн асуултууд тавилаа. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалттай холбоотой нэлээн хэдэн асуултууд тавилаа. Тэн дээр М.Батбаяр сайд хариулаарай.

М.Батбаяр: Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулья.

“Хүүхдийн номын сан”, “Хүүхэлдэйн театр” Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан.

Ингээд энэ 3 жилийн хугацаанд үүнийг барьж байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах ажил зогсоогүй. Газрын асуудал шийдвэрлэгдсэн. Араас нь зураг төслийн даалгавар боловсруулж 2023 оны улсын төсөвт зураг, төслийн асуудлыг суулгасан.

Энэ бол өөрөө том хэмжээний барилга байгууламж учраас хоёр барилгын асуудал. “Хүүхдийн номын сан”, “Хүүхэлдэйн театр.

Тэгээд энэ бол 7, 8 сарын зураг, төслийн ажил үргэлжилсэн.

Өнөөдрийн байдлаар нийтдээ 55.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр улсын экспертизээр зураг төсөв нь батлагдсан байгаа. Энэ ажил урагшаа явж байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь, “Үндэсний урлагийн их театр”-ыг мөн л төсөвт өртгийн хувьд өндөр төсөвтэй. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр бүтээн байгуулагдахаар шийдвэрлэгдсэн.

Одоо хоёрдугаар шатын судалгааны ажлууд нь хийгдээд явж байна.

Манай салбарын тоног төхөөрөмжийн тухайд энэ 3 жилийн хугацаанд Соёлын салбарын хөрөнгө оруулалт хоёр, гурав дахин нэмэгдсэн.

Тэгэхээр энэ бол нийтдээ 452 байгууллага байгаа. Энэ байгууллагууд бүгд нэг дор хоёр, гурван жилийн дотор бүгдээрээ засагдаж шинэчлэгдэж чадахгүй байгаа гэдэгтэй бол санал нэг байна.

Нийтдээ энэ салбарт тоног төхөөрөмжид 37.2 тэрбум төгрөг шаардлагатай байгаа.

Өнөөдөр сумын Соёлын төв ашиглалтад ороод сандалгүй хоёр, гурван жил болж байгаа. Ийм тохиолдол бий. Гэсэн ч үүнийг шаардлагатай тооцоо судалгааг нь бид хийсэн. Энэ оны улсын төсөв дээр 10 тэрбум төгрөг тусгагдаад явж байгаа. Улсын Их Хурал өргөн баригдсан байна.

Энэ хооронд бас мэдээж зүгээр байгаагүй. Барилгын сайдтай хамтарсан тушаал баталж, цаашдаа хийгдэж байгаа шинэ Соёлын төвүүд дээр барилгын бүрэлдэхүүн хэсэгт байх хөшиг, сандал, гэрэлтүүлэг гэх мэт зүйлүүд бол Барилгын хөгжлийн төвөөр хянагдаад улсын комисст хүлээлгэж өгөхөд бүтэн өгдөг байх. Дараа нь эргэж харахгүйгээр зохицуулалтыг хийсэн гэдгийг хэлье.

“Хүүхэд, залуучуудын театр”-ын барилга, мөн “Монголын үндэсний номын сан”-гийн барилга хоёр хоёулаа 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ оны 12 дугаар сард улсын байнгын ашиглалтад авах комисс ажиллах бүх бэлтгэлийг хангасан.

“Хүүхэд, залуучуудын театр”-тай тантай санал нэг байна. Удаан үргэлжилж байгаа. Гэхдээ энд нийтдээ энэ жилийн тухайд гэхэд дөрвөн ч дүүрэг улсын төсвөөр хийгдэж байгаа ажлууд нэгэн зэрэг хоорондоо уялдааг хангах ийм ажлууд явагдаж байгаа.

Дүүргийн хөрөнгө оруулалтаар гадна тохижилтын ажлууд, мөн түүнчлэн замын ажил, дээрээс нь инженерийн бэлтгэл арга хэмжээ, үерийн хөрсний усыг зайлуулах ажлууд ингээд 3 гүйцэтгэгчтэй зэрэг явж байгаа.

Энэ бүх ажлыг хооронд нь зохицуулж ажиллаж байгаа.

Мөн л анхнаасаа зураг төсөв дээр интерьер дизайны шийдэл байхгүй, тайз технологийн шийдэл байхгүй. Энэ нь дараа дараагийнхаа жилдээ бас энэ төсөв зураг төсөл нь хийгдээд дараа нь төсвийн бүрэн бүрдлийг хангасны үндсэн дээр явж байгаа учраас хугацаа хойшилж байгаа гэдэгтэй бол санал нэг байна.

Г.Мөнхцэцэг: Б.Жаргалмаа гишүүн нэмэлт асуултаа тодруулах уу? Б.Жаргалмаа.

Б.Жаргалмаа: Тендерийн хулгай улсын төсвийг алж байгаа гэдгийг Л.Энх-Амгалан сайд хэлээд байна л даа.

Үнэхээр хариуцлагагүй, чадваргүй компани яагаад тендерт шалгаруулаад байдаг юм бэ? Хэчнээн жил энэ тендерийн хулгай, энэ цавчаанд бид идүүлж суух юм.

Татвар төлөгчдийн мөнгийг ийнхүү Барилгын хөгжлийн төвүүд дахиж магадлагаа гаргаад л дахиад төсөв нэмээд оруулаад ирдэг. Жилийн жилд л тэгдэг. Жилийн жилд төсөв нэмэгддэг. Энэ байдлаа халахын тулд Тендерийн тухай хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байгаа шүү гэдгийг дахиад хэлчихье.

Урагшаа явж байгаа. Төсөвт тусгаагдаагүй. 3 жил судалдаг. Төрийн ажил яагаад ийм удаан явдаг юм бэ.

Нэг хувийн компани, төрийн тендерээр шалгарсан компани ажил эхлэнгүүт хувийн компанийнх нь ажил хэзээнээ дуусаад ашиглалтад орчхоод байхад тендерээр гүйцэтгэж байгаа компанийн ажил ерөөсөө урагшаа явдаггүй.

Энэ байдлаа энэ захиалагч энэ хяналт тавьж байгаа төрийн байгууллагууд өөрсдөө хяналт тавих хэрэгтэй. Төр занхайгаад байгаа гэдэг чинь орон тоондоо биш хариулахынхаа асуудалд ер нь байгаа шүү. Дахиад хэлье.

Би тэр сайн мэдээний тухай сонсмоор байна. Консерватурын барилга гэсэн төсөв тавигдсан байна. Хөгжим бүжгийн коллеж буюу.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Л.Энх-Амгалан сайд тэр хөгжим бүжгийн сургуультай холбоотой асуултыг асуугаад байна. Тэр газартай холбоотойгоор нэлээн маргаантай байсан. Төсөвт тавигдсан. Энэ төсөвтэй холбоотой асуултад нь хариулаарай.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг дарга 1 номерын микрофон дээр суугаад сая Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулчихъя.

Б.Батцэцэг: Сайн байна уу? Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын консерваторын цогцолбор барилга Сүхбаатар дүүрэгт 2024 оны төсвийн төсөлд нийтдээ төсөвт өртөг нь 27.1 тэрбум төгрөгөөр,

санхүүжих дүн нь 4.7 тэрбум төгрөгөөр батлагдсан.

Одоо үйл ажиллагаа явуулж байгаа хичээлийн 2 дугаар байр нь 1960 онд, оюутны дотуур байр нь 1962 онд тус тус ашиглалтад орсон. Насжилт өндөр. Газар хөдлөлтөд тэсвэргүй гэсэн ийм дүгнэлттэй.

Газрын хувьд магадлал бол одоогоор Барилгын хөгжлийн төв дээр хийгдээд гарын үсэг зурагдах шатдаа ингээд явж байгаа.

Газрын хувьд ерөнхийдөө маргаантай асуудлууд байгаа. Тэгэхдээ үүнийг нь шийдвэрлэх боломжтой гэж харж байгаа. Энэ дээр Консерваторын зүгээс, Боловсрол, шинжлэх ухааны яамны зүгээс бас хамтарсан ажлын хэсэг гарчихсан явж байгаа.

Г.Мөнхцэцэг: Хөгжим бүжгийн сургуультай холбоотой тэр газрын маргаантай асуудлууд байсан. Тэр нь ер нь цэгцлэгдсэн юм уу, үгүй юм уу гээд асуугаад байх шиг байна.

Тэр дээр яам хариултаа өгөөрэй. 1 номерын микрофоныг өгье.

Б.Батцэцэг: Газрын маргааны асуудал биш ээ. Энэ хажууд нь сургуультайгаа залгаа энэ барилга дээр барьж байгаа юунууд байгаа байхгүй юу. Консерваторын барилга нь өөрөө.

Тэгэхээр энэ дээр газрын маргаан байхгүй.

Г.Мөнхцэцэг: Гүйцээгээд Л.Энх-Амгалан сайд хариулчих. Газрын маргаантай холбоод асуугаад байх шиг байна.

Л.Энх-Амгалан: Консерватор дээр газрын маргаан байхгүй дээ. Б.Жаргалмаа гишүүн ээ.

Өнгөрсөн жил бид нар чинь бас тэнд нэг циркийн сургууль барина гээд. Тэгээд Консерваторынхон чинь бас нэлээн хэрүүл ам хийгээд. Тэгээд үндсэндээ би харин очиж ажилласан болохоороо тэр хажуу талын. Тэр чинь ноднингийн бослого гаражийн эздийн бослого болчихсон юм шүү дээ. Ер нь бол. Ноднингийн бослого бол.

Тийм. Гаражийн эзэд яасан бэ гэхээр хуучин Консерваторын удирдлагад ажиллаж байсан хэсэг багш нар сургуулийнхаа газраас хумслаад нэг барилгад газар өгчихсөн. Тэгээд тэндээсээ тодорхой гаражтай байсан ийм улсууд л эсэргүүцэж боссон.

Харин ч ноднингийн бослого их амжилттай болж манай талд эргэж одоо ингээд алдагдсан байсан газруудыг Д.Сумъяабазар даргатай бид хамтраад яг нөгөө кадастрын зураглалаар нь бид ямар ч маргаангүйгээр тэр гэрчилгээ дээр нь газрын юунуудыг нь олголт хийчихсэн шүү дээ.

Энэ дээр шинэ сургууль барихад ямар нэгэн тийм газрын маргаан байхгүй дээ.

Г.Мөнхцэцэг: Ж.Чинбүрэн гишүүн асуултаа асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 22.5 хувиар нэмэгдсэн гэж энд бичсэн байна.

Тэгэхээр 2024 оноос багш нарын цалин хэдэн төгрөгөөс хэдэн төгрөг рүү

болж нэмэгдэж байгаа вэ гэдгийг та нэг тодорхой болгоод хэлээд өгөхгүй юу?

Хоёр дахь асуудал бол энэ шинжлэх ухааны салбарт бидний оруулж байгаа санхүүжилт үнэхээр бага байгаа. Л.Энх-Амгалан сайдтай санал нэг байна.

Бид үүнийгээ яагаад нэмэх боломж гарсангүй вэ? Үнэхээр болсонгүй юу? Ядаж 5 тэрбум ч гэсэн асар их мөнгө л дөө. 5 тэрбум төгрөгөөр судалгааны маш олон ажлууд хийчих боломж байгаа.

Хоёр дахь нь, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын Үндэсний хорооны даргын багцыг харж байна.

Энэ дээр Б.Бат-Эрдэнэ сайдаас нийтийн биеийн тамирын чиглэлд ер нь мөнгө төгрөг тусгаж чадав уу? 2024 оных энэ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх. Та ч гэсэн үүнийг байнга тогтмол ярьдаг.

Ер нь ялангуяа манай ахмадуудад нийтийн биеийн тамирын чиглэлийн үйл ажиллагаа манлайлал тун дутмаг байна. Үүнтэй холбоотой олон нийтийг хамарсан хөтөлбөрүүдийн төсөв гэж байна уу? Үүнийг хэлж өгөөч ээ.

Соёлын сайдын багцыг харж байна. Энэ дээр өнөөдөр бид бас монгол хэл бичгийн үнэлэмж, хэрэглээ, эрх зүйн орчныг боловсронгуй болгох гээд л ажлын хэсэг ажиллаж байна.

Энэ дээр олон нийтийн сүлжээн дээр контент хийх зардал гэж Соёлын яаманд Та бүхэнд энэ чиглэлээр Соёлын сайдын багц дотор энэ байна уу? Бид монгол хэлээрээ контентуудыг YouTube, Facebook, Twitter дээр бичдэг. Түүгээр манлайлж байгаа улсуудын сайн сайн жишээнүүдийг нь дэмжих ийм бодлого ер

нь харагдаж байна уу? Энэ төсөвтөө энэ орж чадаж байгаа юу гэдгийг асуух гэсэн юм. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Ж.Чинбүрэн гишүүний асуултад Л.Энх-Амгалан сайд хариулья.

Цалингийн нэмэгдэлтэй холбоотой. Тэр шинжлэх ухааны бүтээлтэй холбоотой асуултауд асууж байна.

Л.Энх-Амгалан: Ж.Чинбүрэн гишүүн ээ, сая бид наадмын өмнө Улсын Их Хурал тодотгол хийж, нийт төрийн үйлчилгээнийхээ албан хаагчдын цалинг нэмсэн. Тийм ээ. 40-өөс 60 хувиар нэмсэн.

Энэ дээр боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ганцхан багш биш. Төрийн үйлчилгээнийхний цалин нэмэгдсэн байгаа.

Одоо манай ерөнхий боловсролын багш нарын цалин 1 сая 273 мянган төгрөг болсон. Шинэ тодотголоор.

Сургуулийн өмнөх боловсролын багш нарын цалин 1 сая 337 мянган төгрөг болсон. Тодотголоор.

Одоо ингээд энэ 2024 оны төсвөөр 10 хувь нэмнэ гэж төсвийн 2024 оны хууль орж ирж байгаа.

Тэгэхээр энэ дээр 10 хувь нэмэгдэнэ ээ л гэсэн үг. Нэгдүгээрт. Энэ бол суурь цалин.

Энэ дээрээс нэмээд бид нөгөө үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжээд 2 жил болж байна.

Тэгээд багшийн гүйцэтгэлийн үнэлгээг бид хийгээд 2 жил болж байгаа.

Ингээд үндсэндээ нийт гүйцэтгэлийн үнэлгээгээр манай багш нар 6 түвшинд үнэлэгдэж байгаа шүү дээ. Тийм ээ. 1, 2, 3, 4, 5, 6 гээд. 1-ээс 4 дүгээр түвшин дээр урамшуулал авч байгаа. 1 дүгээр түвшин дээр урамшуулал авч байгаа багш нарын цалинг бид 20 хувийг 50 хувь болгож нэмж байгаа.

Тийм учраас сайн гүйцэтгэлтэй багш нарын үндсэн цалин 50 хувь нэмэгдэх энэ боломжууд нь бас нээгдэж байгаа.

Тэгээд мэдээж 2 дугаар түвшин, 3, 4 дүгээр түвшин дээр байгаа гүйцэтгэл сайн гарсан багш нарын урамшуулал бас үүнийгээ дагаж нэмэгдэж байгаа.

Ерөнхийдөө 01 сарын 01-нээс бид багш нар дээр олгож байгаа багш нарын нэг анги дээр байгаа хүүхдийн ачааллаас шалтгаалж байгаа анги даасан багш нарынхаа нэмэгдлүүд дээр бас жаахан тогтолцооны шинэчлэл хийе ээ гэсэн ийм тооцоо, судалгаанууд хийгдэж байна.

Тэгээд улсын төсөв батлагдсаны дараа бас энэ журам Засгийн газраар орж батлагдана.

Ер нь цаашдаа бидний барьж байгаа гол юу бол нийтээр нь массаараа цалин нэмнэ гэдэг ойлголт байхгүй. Ер нь цалин нэмнэ гэдэг чинь бүтээмж шүү дээ. Тийм ээ. Ж.Чинбүрэн гишүүн ээ.

Тэгэхээр цалингаа нэмэхийг хүсээд байгаа бол бүтээмж л сайн гаргах ёстой.

Тийм учраас бүтээмж нэмэгдэж байж цалин нэмэгддэг учраас илүү өндөр

гүйцэтгэлтэй, сайн гүйцэтгэлтэй багш нарын цалин, урамшууллууд нэмэгдэх, нийгмийн баталгаанууд нь улам баталгаажиж явах энэ тогтолцоо руу л алхах ёстой гэж ойлгож байгаа.

Хоёрдугаар асуудал. Яах вэ Шинжлэх Ухаан Технологийн Санд байгаа шинжлэх ухаанд зарж байгаа мөнгийг бид чамлахаар чанга атга гэдэг шиг яах вэ байгаа дээрээ бид зарцуулж байгаа. Тодорхой үр дүн гарч байгаа. Гэхдээ бид ганцхан урсгал зардал талаас нь хараад байж болохгүй.

Юу вэ гэхээр ер нь сүүлийн 4 жилд манай шинжлэх ухаанд зарсан хөрөнгө оруулалт дээр бид шинжлэх ухаан, технологийн цогцолборыг нийт 148 тэрбум байна уу. Тийм ээ. 148 тэрбум төгрөгийн өртөгтэй ийм цогцолборуудыг барьж байгаа.

Энэ цогцолбор энэ 2024 онд ашиглалтад орно. Ингэснээр юу гэдэг юм энэ 144 тэрбум чинь өөрөө төрөөс шинжлэх ухаанд оруулж байгаа хөрөнгө оруулалт гэдгийг бид давхар тооцож үзэх ёстой юм байна. Үүнийгээ бас давхар тооцож үзэх ёстой гэж ойлгож байна.

Г.Мөнхцэцэг: Олимпын сайд Б.Бат-Эрдэнэ сайдаас төсөв дээр тэр нийтийн биеийн тамиртай холбоотойгоор хэчнээн хэмжээний зардал, төсөв суусан бэ гэж асуулт асуусан. Энэ асуултад Б.Бат-Эрдэнэ сайд хариулья.

Б.Бат-Эрдэнэ сайдын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тийм. Ж.Чинбүрэн гишүүнд баярлаж байна.

Та бол одоо Монголын нэртэй эмч, мэс засалч ийм хүн.

Тэгээд ерөнхийдөө манай эрүүл мэндийн салбарынхан бол тэр байгууллагын амбиц, байгууллагынхаа эрх ашгийг л ярьдаг л даа.

Та бол шал өөрөөр, эрүүл мэндийн салбарын тэр үндсэн хоёр зорилт. Хамгийн эхэнд нь явж байх ёстой тэр нийгмийн эрүүл мэндийн бодлого, зорилтыг бол үнэхээр тэргүүн эгнээнд тавьж байдаг явдалд үнэхээр баярлаж талархаж байгаа юм.

Энэ хүн ардын эрүүл мэндийн асуудал, эрүүлжих, чийрэгжих энэ түвшинг дээшлүүлэхтэй холбоотой асуудал, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгож байж энэ хүн ардын эрүүл мэнд, бүтээлч, идэвхтэй амьдралын гол суурь шалтгаан л тэр шүү дээ.

Харамсалтай нь бид олон арван жил эмнэлэг, эм, эмнэлэгтэй ноцолдсоор байгаад одоо тэрийгээ гүйцэхгүй байгаа юм. Хэчнээн эмнэлэг бариад бариад үүнийг гүйцэхгүй.

Тийм учраас бид урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг л бид сайн зохион байгуулах ёстой юм.

Тийм учраас бид энэ жилийн төсөвт. Ноднин ч мөн ялгаа байхгүй. Бид ноднин 6 тэрбум төгрөгийн санал төсөвт өгөөд 250 сая төгрөг батлуулсан.

Энэ жил гайгүй дэвшилттэй. Бид 8.5 тэрбум төгрөгийн төсөвт санал өгөөд 2.5 тэрбум төгрөг батлагдсан. Үүнийг үр дүнтэй зарцуулна гэсэн бодлоготой байгаа.

Дэлхийн бусад улс орнууд. Одоо тухайлах юм бол Бүгд Найрамдах Солонгос Улс бие бялдрын иргэдийнхээ

сорил тестийг авдаг. Харьцангуй өртөг, зардал багатай ийм тоног төхөөрөмж байгаа юм.

Энэ сүлжээ, сайн дэвшилтэт технологийг оруулж ирэх талаар бид Сангийн яаманд санал тавьсан. Бидэнд эрх зөвшөөрлийг нь олгох байх. Энэ бол хөрөнгө оруулалт биш. Энэ тоног төхөөрөмжийн зардалд зарцуулахаар ийм санал тавиад байгаа юм. Үүнийг анхаарч үзэх байх гэж ингэж бодож байгаа.

Ер нь түрүүн яригдсан. Энэ биеийн тамирын спортын цогцолборуудыг манай Их Хурал дахь албан бус спортын лобби бүлэг 10 гаруй жилийн өмнө 2008 онд бид төрийн бодлого, Их Хурлын шийдвэр болгосон. Харамсалтай нь манай биеийн тамирын салбар нэг бүрэн эрхийн хугацаанд Боловсролын сайдын мэдэлд, нэг бүрэн эрхийн хугацаанд Эрүүл мэндийн сайдын мэдэлд, бүр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдэлд хүртэл хүрсэн.

Тэгээд хаягдсаар явсаар байгаад одоо ингээд нийслэлийн 9 дүүрэгт баригдах спортын цогцолборууд чинь газар нь байхгүй, газрыг нь сонгож чадаагүй. Одоо арав гаруй жил үргэлжлээд явж байгаа ийм зүйлүүд байна шүү дээ.

Түрүүн Ц.Мөнхцэцэг гишүүний хэлдгээр Сүхбаатар дүүргийн биеийн тамир спортын ордон гэхэд Монгол Улсын Их Сургуулийн газартай давхцуулаад олгочихсон. Санхүүжилт зардал нь одоо ингээд өсөөд яваад байдаг.

Баянзүрх дүүргийн спортын цогцолбор ордон гэхэд жишээлэх юм бол тэр орчмын үерийн аман дээр газар өгөөд

барьчихсан. 4, 5 жилийн үерийн гамшигт нэрвэгдээд, ингээд подвалын нэг давхар нь байнга үерт автдаг.

Тэгээд үерийн нэг даланг барьж байгуулах шаардлагатай. 2.7 тэрбум төгрөгийн төсөвт манай талаас санал оруулчихсан байгаа. Энэ маань батлагдаж орох юм бол тэр спортын цогцолборыг үерээс хамгаалах гээд байгаа юм биш. Тэр орчмын байгууллага, иргэд. Баянзүрх дүүргийн. Үүнийг бүхлээр нь хамгаалах тухай ийм асуудал.

Тэгээд Сангийн сайдтай өөрийнхөө сонгогдсон тойргоос Дарханы спортын цогцолбортой бид танилцаж байна. Шадар сайд С.Амарсайхантай Налайх, Баянзүрх гээд энэ спортын арав гаруй жил болсон ийм юмнуудтай л явж байгаа.

Тэгээд үүнийг ярихаар зэрэг одоо байгаа улсууд руу нь л нүдээд байна шүү дээ.

Г.Мөнхцэцэг: Б.Бат-Эрдэнэ сайд гүйцээгээд хариулчих уу. Болчихсон уу? Хариулт болчихсон уу?

Соёлын яам. Соёлын сайдаас л асуулт асуугаад байдаг.

Монгол хэл дээрх энэ контентууд нийгэмд их хэрэгтэй байна. Энэ чиглэлээр сайдын төсөвт юу туссан юм бэ гээд Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулаарай.

М.Батбаяр: Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулья.

Монгол хэлээр бүтээгдэж байгаа, тэр дундаа хүүхдэд зориулсан энэ контентууд хэрэгцээ шаардлагатай байгаа гэдэг дээр тантай санал нэг байгаа.

Тэгэхээр мэдээж Соёлын сайд ерөнхийлөн захирагчийн урсгал төсөв дээр соён гэгээрлийн чиглэлээр номын сан, соёлын төвүүдээр дамжуулаад хөтөлбөр хэрэгжүүлэх зардал тусгагдсан. Энэ зардлын хүрээнд хэрэгжүүлэх боломжтой нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, мөн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр буюу хөтөлбөр, арга хэмжээнд ч гэсэн мөн монгол хэлээр. Дээрээс нь хүүхдэд зориулсан контент зарцуулах ийм хөрөнгө мөнгө тусгагдаж байгаа гэдгийг хэлье.

Гуравдугаарт нь, Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгөөр төслүүдийг тухайн жилдээ санхүүжүүлдэг.

Энэ оны тухайд гэхэд нийтдээ 16 төсөл, арга хэмжээнд 672.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2022 онд тухайлбал бид 50 хувьд нь зөвхөн хүүхдэд зориулсан уран бүтээл. Тэр дундаа монгол өв соёл, монгол хэлээрээ сурч, боловсрох, түүнийгээ мэдэхтэй холбоотой контентыг санхүүжүүлэх шийдвэрийг хүртэл гарган хэрэгжүүлж байсан.

Ц.Мөнхцэцэг: Ж.Чинбүрэн гишүүн нэмж тодруулах асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Л.Энх-Амгалан сайд нэг чухал зүйл хэллээ. Та.

Ер нь анги дүүргэлтээс хамаарч багш нарын цалинг боддог байх нь өөрөө их чухал байна. Зөвхөн гүйцэтгэл гэхгүй. Тэгэхгүй бол 40 хүүхэдтэй багшилж байгаа, 20 хүүхэдтэй багшилж байгаа хоёр багшийн ачаалал асар их. Энэ дээр бид үр дүнг нь бас нэлээн тийм индексжүүлж өөрөөр харахгүй бол болохгүй.

Тэгэхээр 2024 оны 01 сарын 01-нээс энэ арга хэмжээ хэрэгжинэ гэж хэлж байгаад баяртай байна.

Тэгээд Соёлын яам яг тэдийг зарцуулсан гээд тоо хэлбэл их зүгээр байх юм. Одоо тийм тийм контентыг яг бодитой ийм мөнгө зарцуулчихлаа гээд. Жишээлэх юм бол социал дээр байгаа контентуудыг дэмжих бодлого байхад та бүхэнд хууль эрх зүйн хувьд түвэгтэй, бэрхшээлтэй зүйл учирч байв уу? Одоо яг хэдэн төгрөг зарцуулчихаад явж байна гээд яг тодорхой тоо яривал их сайн байна.

Г.Мөнхцэцэг: М.Батбаяр сайд нэмж тэр тодорхой тоо баримттай зүйл ярина. 1 номерын микрофоныг өгье. М.Батбаяр сайдын микрофон.

М.Батбаяр: Ж.Чинбүрэн гишүүний асуултад нэмж хариулья.

Тэгэхээр контент бүтээхтэй холбоотой зардал тусгагдав уу гэдэг дээр би хариуллаа. Зардал бол түрүүний миний хэлсэн хоёр чиглэлээр тусгагдаж байгаа. Цаашдаа ч энэ чиглэлээр тусгагдаад явна.

Тоо хэл гэсэн учраас. Тухайлбал, Соёл, урлагийг дэмжих сангийн сүүлийн 3 жилийн тоогоор 2021 онд нийт 42 төсөл, арга хэмжээг 1.6 тэрбум төгрөгөөр контентуудыг санхүүжүүлсэн.

2022 онд 34 төсөл, арга хэмжээг 1.4 тэрбум.

2023 онд 19 төсөл, арга хэмжээг 651.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон ийм тоог танд хэлье.

Г.Мөнхцэцэг: Б.Баярсайхан гишүүн асуултаа асууя. Б.Баярсайхан гишүүний микрофоныг өгье.

Б.Баярсайхан: Соёлын сайдаас хоёр асуулт асууя. Спортын сайдаас нэг асуулт асууя.

Сая контент бүтээхэд 1.6 тэрбум төгрөг зарцуулсан гэж байна. Тэгээд бага насны хүүхдэд зориулсан гар утасны ямар ямар контент өнөөдөр хүүхдүүдийн хэрэглээ болоод явж байгаа юм бэ?

Энэ жилийн төсөв дээр хэдэн төгрөг тавигдаж байгаа вэ? Хэдэн контент бэлдсэн бэ? Ямар нэртэй, хаагуур түгээн дэлгэрүүлэгдэж байгаа юм бэ гэдгийг асууя.

Хоёрдугаарт, Соёлын яамны чиг үүргийн нэг чухал хэсэг нь монгол иргэдээ соён гэгээрүүлэх, соёлжуулах ажил байгаа.

Энэ чиглэлээр 2024 оны төсөвт хэдэн төгрөг суусан бэ? Санхүүжилтийн хэмжээг хэлж өгнө үү?

Б.Бат-Эрдэнэ сайдаас энэ иргэдийн бие бялдрын хөгжил, эрүүл байх үндэс нь бол яахын аргагүй нийтийн биеийн тамирын асуудал байгаа.

Тэгэхээр төсөвт хэдэн төгрөг тусгагдсан юм. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт, Засгийн газрын зорилтод орчихсон байгаа. 4 жилийн. Бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг биеийн тамирын тоног төхөөрөмжөөр хангана гэсэн зорилтын хэмжээнд хөрөнгө тавигдаж байгаа юу? Анэ асуултууддаа хариулт авъя.

Г.Мөнхцэцэг: М.Батбаяр сайд Б.Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

2024 онд хийгдэх контентуудад хэчнээн нь яг ийм үндэсний. Тийм. Хаагуур түгээгдэж байгаа юм гэж асууж байна. Тийм ээ. Тодорхой хариулаарай. Тоо баримттай хариулна шүү.

М.Батбаяр: Б.Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

Өнөөдөр монгол хүүхдийг соёлын боловсрол олгох, мөн хичээлийн бус цагаараа дугуйлан, секцэд хамрагдах, соёлын боловсролыг дээшлүүлэх, бусад гэр бүлийн хүмүүжил олгох гээд олон асуудлууд бий.

Түүнтэй холбоотойгоор контент бүтээж, түүгээр хүүхдийн хүмүүжилд нөлөөлөх энэ ажил бол нэг л ажил нь гэж би хэлмээр байна.

Контентын тухайд мэдээж түрүүний би хэлсэн сайдын хөтөлбөр, арга хэмжээ болон бусад энэ соён гэгээрүүлэх зардлаас гадна тодорхой санхүүжүүлж байгаа нь энэ Соёл урлагийг дэмжих сангаараа зарцуулж байгаа.

Соёл урлагийг дэмжих сангийн тухайлбал би 2022 оны хүүхдэд зориулсан уран бүтээл, контент бүтээхтэй холбоотой 50 хувийг нь санхүүжүүлсэн. 34 төсөл арга хэмжээний 16-г нь хүүхдэд зориулсан уран бүтээлийг санхүүжүүлсэн.

Тэгэхээр гар утасны аппликэйшн үндсэндээ 6 чиглэлээр 80 минутын хөтөлбөрүүдийг хийсэн. Мэдээж гар утсаар богино хэмжээний контентуудыг явуулж байгаа.

Гэхдээ шууд өрсөлдөх хэмжээний контентууд хараахан гарч чадахгүй байгаа гэдэгтэй санал нэг байна. Контентыг бид цаашдаа ч сайн контентыг гаргахын төлөө зардлаа тусгана.

Зөвхөн контентоос гадна бусад бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр системтэй ажлуудыг хийж байгаа. Өнөөдөр хүүхдэд зориулсан уран бүтээлийг тайзны бүтээлээр ямар бүтээлийг авч болох юм. Мөн түүнчлэн дүрслэх урлагийн бусад чиглэлүүдээр хүүхэд очих тэр нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд хүртэх, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх гэдэг ийм олон талын арга хэмжээ авч байж энэ бодит үр дүнд хүргэнэ гэдгийг танд хэлье.

Г.Мөнхцэцэг: Б.Бат-Эрдэнэ сайдаас асуусан асуултад хариулчихъя. Тэгээд тэрний дараагаар дахиад Б.Баярсайхан гишүүн нэмж тодруулж болно.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Б.Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн эрүүл мэндийн асуудалд манай биеийн тамир спортын салбар их чухал оролцоотой байгаа юм.

Тэгэхээр Монголд их олон арван жил тогтсон нэг ойлголт бол биеийн тамир, спорт гэхээр зэрэг спортын тухай асуудал, тэмцээн, уралдаанд оролцох тухай асуудал ойлгогддог.

Энэ нийт хүн амд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн энэ том зорилтыг биелүүлэхэд биеийн тамир, спортын салбар чухал үүрэгтэй гэдгийг төдийлөн анхаарч хайхарч үздэггүй.

Тэгээд ингэж явж ирсэн энэ ойлголт л хэвээрээ үргэлжлээд байгаа юм л даа.

Тэгэхдээ манай Засгийн газар, Сангийн яам, Улсын Их Хурал биеийн тамирын салбар дахь санхүүжилт, энэ үйл ажиллагааг хэвийн хангахад их онцгойлон анхаарч байгаа. Тэнд талархаж байгаа.

Би түүрүүн хэлсэн. Энэ жил нийтийн биеийн тамирын салбарт зарцуулах хөрөнгийг тодорхой хэмжээнд бидний оруулсан саналаар баталж өгөөгүй ч гэсэн тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж өгсөнд талархалтай байгаа.

Үүнээс гадна юуны өмнө биеийн тамирын салбарын ажиллагсдын аймаг, нийслэлийн биеийн тамирын хороонд ажиллаж байгаа бүх шатны хүмүүсийн цалин, нийгмийн баталгааг нэмэгдүүлж өгсөнд туйлын талархалтай байгаа шүү.

Өмнө нь шигшээ багийн тамирчдын цалинг 1.2 сая, дасгалжуулагч 1.5 саяар болгож нэмэгдүүлсэн байхад биеийн тамирын салбарын бүх түвшинд ажиллаж байгаа хүмүүсийн цалин 700-аас 800 мянган төгрөгийн хооронд ийм хэт зөрүү ялгаатай.

Ингээд биеийн тамирын салбарт ажиллах хүмүүс олдохгүй. Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багшийн цалин арай дээр учраас тийшээгээ шилжээд байдаг ийм хүндрэлтэй нөхцөл байдалтай байсан.

Харин үүнийг 7 сард Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлогын хүрээнд эрс нэмэгдүүлж өгсөнд манай салбарынхан талархалтай байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Ингээд энэ жилийн нийтийн биеийн тамирын төсөв зардал 2.5 тэрбум төгрөг батлагдсан. Энэ төсөв зардлыг үр дүнтэй ашиглах талаар манайхан бүх түвшиндээ ажиллана.

Улсын хэмжээнд жилдээ 3 мянга гаруй уралдаан тэмцээн, спортын арга хэмжээнд нийт хүн амын чинь гуравны нэг нь буюу 1.1 сая хүн оролцож байгаа юм. Үзэгчдийг оролцуулаагүй шүү. 8 наснаас 80 настныг хүртэлх энэ орон зайд.

Монголын ард түмэн чинь их биеийн тамир спортлог ийм сайхан ард түмэн байна шүү дээ. Тэгээд энэ дээр дэлхий нийтэд хөгждөг тэр жишгийн дагуу. Түрүүн Ц.Мөнхцэцэг гишүүн ч хэлж байгаа.

Тэр маш зөв зүйтэй. Энэ спортын орой дээр нь байж байгаа энэ шилдэг тамирчид олимп, дэлхийн юу байдаг юм ийм их спортын тамирчид маань, дасгалжуулагчид маань бүх талаар үлгэрлэж манлайлах ёстой хүмүүс. Сайны үлгэртэй байж энэ олон нийт чинь энэ биеийн тамир спортод дуртай болж, үр хүүхдүүдээ хичээллүүлж, өөрийнх нь эрүүл мэнд, ирээдүйн итгэл, сэтгэл санаа юу байдаг юм энэ бүх юм чинь тэрнээс шалтгаалдаг учраас энэ том зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар анх удаа биеийн тамирын асуудал эрхэлсэн энэ салбар дундын уялдаа зохицуулалтыг хангах сайдын албыг бий болгоод Та бүхэн маань нийгэмд нэг эерэг хандлага, эерэг нөлөөллийн энэ ажил лыг түүчээлж манлайлаач гээд ийм том зорилт дэвшүүлээд бид ажиллаж байгаа юм шүү дээ.

Тийм учраас энэ соёлын салбарынхан, нийгмийн хамгааллын салбарынхан, эрүүл мэндийн салбарынхан, боловсрол, бүх салбарынхан энд бид нэг зорилгоо нэгтгэж ажиллах ёстой юм.

Л.Энх-Амгалан сайд бид хамтраад тодорхой үр дүн гарч байгаа.

Ер нь хүний хөгжлийн асуудал, боловсролын тогтолцоонд эрүүл мэнд, биеийн тамирын хичээл, урлаг, гоо зүйн хичээл, хөдөлмөр технологийн хичээл ерөөсөө энэ хөгжил дэвшилд хүрсэн улс орнуудын боловсролын тогтолцоондоо баримталсан суурь бодлого бол энэ байна.

Одоо хуульд үүнийг оруулах арга байхгүй. Б.Бат-Эрдэнэ ээ. Одоо бид энэ хөтөлбөрийн шинэчлэлээр үүнийг оруулна гэж манай сайд олон удаа ам өчгөө өгч байгаа.

Г.Мөнхцэцэг: Б.Баярсайхан гишүүн тоног төхөөрөмж хэр суусан бэ гэж асуугаад байгаа. Тэгээд тэр дээр Б.Бат-Эрдэнэ сайд гүйцээж хариулъя. Б.Бат-Эрдэнэ сайдын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Манай Сангийн яамныхан энэ жил энэ тоног төхөөрөмжийн зардалд. Хуучин огт юм тусгаж байгаагүй. Тэгээд энэ жил бол 3.6 тэрбум төгрөг тусгаж өгсөн.

Энэ тоног төхөөрөмжийн зардал юунд зарцуулагдах вэ гэхээр ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын хичээлийн тоног төхөөрөмж огт зарцуулагдахгүй шүү.

Энэ манай харьяа аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын хороодын тэр үйл ажиллагаанд л

зарцуулагдах ёстой. Тэгээд шигшээ багийн тоног төхөөрөмжийг шинэчлэхтэй холбоотой ийм зүйлд л зарцуулагдана.

Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын хичээлийн тоног төхөөрөмж, заал танхимын стандарт, энэ бүх асуудлыг эрхэм хүндэт Л.Энх-Амгалан сайд бүрэн хэмжээнд хариуцна.

Эрүүл мэндийн салбар танай салбарыг санхүүжүүлдэг юм уу?

Г.Мөнхцэцэг: Б.Баярсайхан гишүүний асуултад үндсэндээ хариуллаа.

Тэгэхээр тодруулж Б.Баярсайхан гишүүн бас асуулт асууя гэж байна. Б.Баярсайхан гишүүн асуултаа асууя. Тодруулья.

Б.Баярсайхан: М.Батбаяр сайд аа, Ч.Номин сайд байхгүй юм уу? Тийм ээ.

Соёлын яамнаас миний асууж байгаа асуултад холбогдох газар хариулаач. Тэгэх үү? Энэ контент бол хийгээд байгаа юм байна.

Өнгөрсөн жил 16 төсөл, арга хэмжээ хийчихсэн юм байна. Тэгээд монгол контент бага насны хүүхдэд зориулсан.

Энэ чинь хаагуур түгээгдэж байгаа юм бэ? Хүүхдүүд гар утасны хэрэглээнд хөхнөөсөө дөнгөж гараагүй байгаа хүүхдүүд хүртэл гар утасны ийм донтолтод орж байна. Монгол хэл мартагдаж байна. Гар утасны контент хийгээд өгөөч ээ гэж хэлж байгаа.

Тэгээд чанаргүй болчихсон гэж яг ямар зүйлс чанаргүй болоод, хэдэн төгрөг төсөвлөгдөөд, хэдэн төгрөгийн санхүүжүүлсэн төслүүд нь чанаргүй

болчихсон юм бэ? Сангийн яам хариулаад өгөөч.

Г.Мөнхцэцэг: М.Батбаяр сайд ээ. Гишүүдийн асуултад бүр тодорхой баримттай хариулмаар байна.

Тэгээд хэрвээ та өөрөө хариулж чадахгүй байгаа бол тэр салбарын хариуцсан хэлтсийнх нь дарга нараар хариултыг нь өгүүлээч. Соёлын сайд хаачсан юм бэ гээд дахин дахин асуугаад байгаа юм биш үү. Тийм ээ.

М.Батбаяр: Б.Баярсайхан гишүүний асуултад хариулья.

Соёлын сайд хөдөө томилолтоор ажиллаж байгаа.

Гар утасны контентыг би чанаргүй болсон гэж хэлээгүй. Гишүүн ээ.

Миний гарт нийтдээ 38 контент линктэйгээ байна. Би үүнийг танд бичгээр хүргүүлж өгье. Энэ хооронд контентууд хийгдэж байгаа. Тэгэхдээ би танд хэлж байгаа нь гар утсанд зөвхөн контент хийхэд зориулж хийж байгаа ажил нь нэг л ажил нь. Тийм.

Тийм учраас надад энэ 36 контентын жагсаалт байна. Би үүнийг танд бичгээр хүргүүлье. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, өнөөдөр хүүхдэд зориулсан бусад арга хэмжээг зохион байгуулж байгаа. Би тэгээд түүн дээр бас нэг тоо хэлье.

2023 онд бид нийт.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Их л товч тодорхой асуулт асуугаад байгаа шүү дээ. М.Батбаяр сайд аа, хэрвээ та өөрөө

мэдэхгүй байгаад байгаа бол энэ хэлтсийн дарга нар, газрын дарга нараараа хариулал л даа. Тийм.

Б.Баярсайхан гишүүн нэмж асуултаа тодруулж асууя.

Б.Баярсайхан: Ж.Чинбүрэн гишүүн ч гэсэн асуугаад байна шүү дээ. М.Батбаяр сайд аа. Танаас.

Бид монгол хэл бичгийн соёлын асуудал өнөөдөр үндэсний хамгийн чухал асуудал болоод байгаа учраас.

3 жил танайхаас бид бага насны хүүхдэд зориулсан монгол хэлээр ярьдаг хүүхдийн сонирхлыг татахуйц нас сэтгэхүйн онцлогт нь таарсан контент та нар үйлдвэрлэж байгаа гэж 3 жил ярьж байгаа шүү дээ.

Тэгээд тэр төсөв нь энэ жил суусан юм уу гэхээр та ноднин жил суугаад 1.6 тэрбум төгрөг зарцуулчихсан гээд. Тэгвэл ямар контент бий болгосон юм бол оо. Одоо хэр үр дүнтэй явагдаж байна, хаагуур түгээн төрд дэлгэрүүлэгдэж байгаа юм бэ? Монгол хүүхдүүдийн хүртээл болж байна уу гэж асуугаад байна шүү дээ.

Г.Мөнхцэцэг: Соёлын яамнаас яг энэ асуултад хариулах эрх бүхий хүмүүс ирсэн байх ёстой.

С.Батхуяг дарга, газрын дарга нар бүгдээрээ ирсэн байна. Газрын дарга нараас С.Батхуяг дарга, Б.Сэргэлэн дарга гүйцэд хариул. Тэр 1 номерын микрофон дээр очоод суучих.

Тэгээд Б.Баярсайхан гишүүний асуултад гүйцээж тоо баримттай хариулна шүү.

Г.Батхуяг: Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацийн хэлтсийн дарга Г.Батхуяг.

Манайх Соёл урлагийг дэмжих сан, Кино урлагийг дэмжих санг давхар хариуцаж ажилладаг. Нэг нэг мэргэжилтэн хариуцаж ажиллаж байгаа.

Ер нь зардлууд нь түрүүн танилцуулагдсан. 1.5 байж байгаад сүүлдээ бүр 800 сая болж буурсан байгаа.

Сангууд нь өөрсдөө зөвхөн гар утасны гэдэг юм уу, цахим контентоос илүү журам нь өөрөө нийтлэг. Бүх төрлийн, хүүхдийн болон бусад уран бүтээлийг дэмжих ийм өргөн хамрах хүрээтэй байдаг.

Тэгэхдээ яг таны асуусан асуултад хариулахын тулд дэмжигдсэн төслүүдээс зөвхөн сангаар хязгаарлаж энэ асуудлыг хариулахад түвэгтэй л байх. Тэгэхдээ 2023 онд дэмжигдсэн төслүүдээс зөвхөн.

Монголын нууц товчоо, эртний уран зохиол гэдэг төслийг хүртэл дэмжсэн.

Г.Мөнхцэцэг: Асуултад хариулт хангалтгүй л байгаад байна.

Тэгээд энэ асуудлыг ер нь дараа нь Байнгын хороогоор ер нь авч хэлэлцэхгүй бол, асуудал болгож оруулж ирэхгүй бол ер нь мэдээллийг бид авч чадахгүй л юм байна л даа.

Б.Баярсайхан гишүүний хариулт хангалтгүй байна. Хоёр удаа тодруулчихлаа. Горимоороо явчихлаа. Тийм.

Би бас хоёр, гурван зүйлийн асуултыг Соёлын яамнаас асууя гээд бэлдсэн юм.

Соёлын сайдын багцад бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 22 тэрбум 620 сая 500 мянган төгрөг төсөвлөсөн нь өмнөх оныхоос 1 тэрбум 951 сая төгрөгөөр нэмэгдсэн гэж аудитын дүгнэлтэд орсон байгаа юм.

Тэгээд **“Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн Үндэсний хороо”**-ны үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгасан гэж тайлбарласан байгаа юм.

Энэ мөнгө юунд зарцуулагдсан юм? **“Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хороо”** гэж яг ямар хороо байгаа юм? Тийм. Үүний зарцуулалтыг. Энэ дээр тайлбар хэлээдхээч. Нэг.

Хоёрдугаарт, Соёлын сайдын багцад Төв номын сангийн барилга гэж мөн олон жил үргэлжилж байна. Би үндсэндээ 8 жил бараг үүнийг ярьж байна шүү дээ.

Тэгээд өнгөрсөн жилээс эхлээд 90 хувьтай явж байгаа л гээд байдаг. Хэдэн жил 90 хувьтай байдаг юм бэ?

Байшин маань үндсэндээ босчихсон. Дотор нь байгаа тоног төхөөрөмж дутуу байгаа гээд өнгөрсөн жил нэлээн их маргаан дагуулж байж энэ чинь 3.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байх ёстой. Энд ер нь юу хийгдсэн юм. Хэзээ яг 100 хувь болгож ашиглалтад оруулж хүлээлгэж өгөх гэж байгаа юм?

Гуравдугаарт, **“Соёл урлагийг дэмжих сан”** гээд 2023 онд 19 төсөл, арга хэмжээнд 651.0 сая төгрөг олгосон байгаа юм.

2024 онд 3 тэрбум төгрөгийн төсвийн санал хүргүүлснээс 800.0 сая төгрөг тавигдсан гээд.

Эд нар дээр юу хийгдсэн, ямар судалгаа тооцоо байгаад байгаа юм бэ? **“Кино урлагийг дэмжих сан”** гэж бас байна.

2020 онд 10 тэрбум төгрөг тавигдаж байсан санагдаж байна.

2022 оны 1 дүгээр сард Кино урлагийг дэмжих хууль хэрэгжсэн. Энэ хуулийн хүрээнд зөвлөл байгуулагдсан. Тодорхой журмууд гарсан. 2023 онд 2 удаа сонгон шалгаруулалтаар 11 төсөл, арга хэмжээ хэрэгжчихсэн гээд байгаа юм.

Тэгээд 1 тэрбум 339.0 сая төгрөг зарцуулсан гээд байна. Эхний шалгаруулалтаар 11 төсөл дээрээ.

Хоёр дахь шатанд нь 10 төсөл арга хэмжээнд 1 тэрбум 256 сая төгрөг олгохоор шийдвэр гаргасан гээд байна.

Тэгээд одоо яг энэ гишүүдийн асуугаад байгаа яг үндэсний контентууд хаана хийгдсэн юм? Ер нь ямар кинонд энэ төслүүд нь зориулагдсан юм, зарцуулагдсан юм гээд ингээд бүр нарийн тоо баримттай та бүгдийн хийгдсэн ажлыг чинь асуугаад байгаа шүү дээ.

Тэгээд энэ дээр ийм асуултуудад ерөөсөө хариулт өгч чадахгүй байх юм. Энэ дээр хэн хариулт өгөх юм. 1 номерын микрофон дээр яг хариулах ёстой хүмүүс нь очоод суугаад хариултаа өг дөө.

М.Батбаяр: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Үлдсэнийг Л.Энх-Амгалан дарга хариулна.

“Монголын Үндэсний номын сан”-гийн барилга үргэлжлээд явж байгаа. Энэ оны 12 дугаар сард улсын байнгын ашиглалтад хүлээж авна.

Энэ оны 12 дугаар сард барилгад нүүж орох нөхцөл бүрдэнэ гэж хариуцлагатайгаар хэлье.

Тэгэхээр өнгөрсөн оны тухайд барилгыг дуусахтай холбоотой асуудлууд байсан. Мэдээж 2022 онд энэ барилга доголдсон. Доголдох шалтгаан нь үндсэн барилгын гүйцэтгэгч харамсалтай зүйл болж бурхан болсонтой холбоотойгоор хагас жилийн хугацаанд доголдсон.

Үүнээс хойш шинэ гүйцэтгэгч ажилд ороод энэ оны туршид эрчимтэй барилга угсралтын ажил үргэлжилж байгаа.

Мөн түүнчлэн шинэ барилгад орох гэж байгаатай холбоотойгоор нийт 14 багц тоног төхөөрөмжийн тендерүүд зарлагдсан. Нийтдээ 1-ээс 12 дугаар багц зарлагдаад нийлүүлэгдсэн байгаа. Одоо барилгад зэрэг суурилуулагдаад явж байгаа гэдгийг хэлье.

Сүүлийн багцын тухайд барилгад тавилга нийлүүлэхтэй холбоотой энэ 2 багц нь худалдан авалтын үйл ажиллагаа зохион байгуулагдаж байгаа.

Тийм учраас энэ оны 4 дүгээр улиралд 12 сард бүрэн болно гэж ойлгож болно.

Хоёрдугаар асуудал дээр **“Кино урлагийг дэмжих сан”** нийтдээ 10 тэрбумын нийт хөрөнгийн хэмжээтэй.

Түүнээс хойш 2022 оны 01 сарын 01-нээс Кино урлагийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт эхэлсэнтэй холбоотойгоор Киноны зөвлөл байгуулагдсан. Түүнтэй холбоотой энэ хөрөнгийг захиран зарцуулах сангийн журмууд батлагдаж, 2022 оны 4 дүгээр улиралд нэг шийдвэр гарсан. Тэр нь сая таны хэлсэн 11 төсөл, арга хэмжээ 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн.

Энэ Кино урлагийг дэмжих тухай хуулийн санхүүжилт олгох журмаар уран сайхны кино, баримтат кино, мөн киноны мэргэжилтнийг сургах гэсэн ийм тодорхой чиглэлүүд дээр олгогддог.

2023 онд мөн нэг төсөл сонгон шалгаруулалт зарласан. Түүн дээр нийтдээ 16 төсөл, арга хэмжээ 1.2 тэрбум төгрөгийн төсөл шалгарсан байгаа. Санхүүжилтийг олгож эхлээгүй байгаа.

Тэгэхээр Монгол кинонд санхүүжилт олгож эхэлсэн нь Монгол киночдыг хөгжүүлэх, олон улсад, дэлхийн зах зээл дээр гаргах, мөн “А” зэрэглэлийн кино наадамд Монголын уран бүтээлчдийг оролцуулах боломж нээгдсэн.

Үүнтэй холбоотойгоор эхний “А” зэрэглэлийн наадмуудад Монголын киночид амжилттай явж байгаа гэдгийг Та бүхэн маань бүгдээрээ мэднэ.

“Соёл урлагийг дэмжих сан”-гийн тухайд 2024 оны улсын төсөв дээр нийтдээ 3 тэрбум төгрөгийн санал өгсөн. Энэ саналд бид тооцоо, судалгаа хийсэн. Юу вэ гэхээр 2023 онд 19 төсөлд олгогдсон ч гэсэн нийтдээ 63 төсөл, арга

хэмжээний 13 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүсэлт бол ирсэн.

Тийм учраас энэ бол нэг талаасаа бас контент бүтээх, кино бүтээх соёлын чиглэлээр арга хэмжээ явуулах идэвх санаачилга байна гэсэн үг.

Тийм учраас бид 20 хувиар нь тооцож 3 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгах саналыг хүргүүлсэн ч одоогоор Улсын Их Хуралд 800.0 сая төгрөгийн санхүүжилт тусгагдаад явж байна.

Г.Мөнхцэцэг: Миний ярьсан зүйлийг буцаагаад эргүүлээд өөрт нь хариулт болгоод ингээд яриад байх юм.

Тэгээд энэ удаагийн хуралдаанаар ер нь нэг тодорхой хариулт бид Соёлын яамнаас авахгүй юм байна. Гишүүд ч бас ийм гомдолтой байна. Тийм.

“Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хороо” гэж ямар газар байдаг юм? Энэ ямар үйл ажиллагаа явуулсан юм?

22 тэрбум 620 сая 500 мянган төгрөг төсөвлөсөн гэж байна. Өмнөх оныхоос 1 тэрбумаар нэмэгдсэн гэж байна. Бараг 2 тэрбум шахуу төгрөгөөр нэмэгдсэн гэж байна. Энд юу хийх гэж ямар байдлаар төсөвлөсөн юм?

Ч.Энх-Амгалан: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья. Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Ч.Энх-Амгалан байна.

“Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах үндэсний хороо”-г сая гуравдугаар улиралд Засгийн газрын хуралдааны тогтоолоор байгуулагдсан байгаа.

Энэ хороо маань 2022 оны гуравдугаар улирлаас эхэлж үйл ажиллагаа явуулж байгаа.

Энэ Соёлын яамны дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа. 5 хүний ажлын албаны бүрэлдэхүүнтэй.

Өнөөдөр төсөв захиран зарцуулсан асуудал байхгүй.

2024 оны төсөв дээр нэмэгдсэн төсвийг сая аудитын дүн дээр тавигдсан байгаа.

Энэ нь Монгол Улсыг ирэх жил **“Welcome to Mongolia”**-гийн хүрээнд, мөн олон улсад сурталчлах жилийн хүрээнд 5 тэрбум төгрөгийг ирэх 2024 оны төсөв дээр суулгаад явж байгаа гэдгийг хэлэх байна.

Хоёр дахь нь, саяын контенттой холбоотой зүйл дээр би бас нэмэлт мэдээлэл өгье гэж бодож байна.

Энэ хүүхдийг соён гэгээрүүлэх, хүүхдийн гоо зүйн мэдлэг олгох, уран бүтээлийг туурвих чиглэлээр 2021 онд 6 төсөл 196 сая, 2022 онд 19 төсөлд 828.0 сая, 2023 онд 3 төсөлд 103.0 сая төгрөгийг контент үйлдвэрлэл, телевизийн нэвтрүүлэг, анимэйшний чиглэлээр санхүүжүүлсэн байгаа.

Үүний үр дүнд **“Мөнх Тунх: Ямар нэг юм аварсан нь”** аппликэйшн бол амжилттай хэрэгжиж явж байгаа.

Мөн “Соёлын өвийн дурсгалыг хүүхдийн нүдээр” чиглэлээр нийт 3-аас 6 минутын хугацаатай ийм 62 контент үйлдвэрлэлийг Үндэсний болон бусад телевизүүдээр явуулж байна.

Г.Мөнхцэцэг: Тодорхой хариулт ирэхгүй юм байна.

Ингээд Б.Бат-Эрдэнэ сайд асуулт асуух юм уу? Б.Бат-Эрдэнэ сайдын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Тийм. Би нэг зүйл. Соёлын яамныхан тодорхой хариулт өгөхгүй байна л даа.

Гадаа биднийг гарахаар сэтгүүлчид биднээс асуулт тавиад байгаа байхгүй юу. Зарим сэтгүүлчдийн төлөөлөл энд сууж байна. Энэ хүмүүс маань энд асуух бололцоо байхгүй учраас би асуух гээд байгаа юм.

Яагаад гэвэл улсын хэмжээнд 150 соёлын төв, театрын барилга барихаар төсөвлөчихсөн гэж яриад байгаа юм. Энэ ямар үндсэн шаардлагаар барьсан юм бэ? Ийм хэмжээний юм байгаа юм уу, байхгүй юм уу гээд. Нэг.

Нөгөө талынх нь юм би юу хэлэх гээд байна вэ гэхээр Хэнтий аймгаас сонгогдсон 3 гишүүн нэгдсэн ажлын албатай.

Дээрээс нь бид энэ мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг иргэдээрээ эрэмбэлүүлдэг. Тухайлах юм бол 2020 оны 9 сард бүх сум, суурин газруудаар яваад иргэдээр эрэмбэлүүлээд. Аль нь чухал юм гэдгийг дахиж эрэмбэлүүлээд. Тэр сумын Засаг даргын саналаар гэсэн үг биш шүү дээ. Иргэдээр эрэмбэлүүлээд төсөвт тусгуулаад хэрэгжүүлээд явж байгаа.

Тэгэхээр энэ зарчмыг Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газар улс орны хэмжээнд энэ зарчмыг баримталж байна гэж би ингэж ойлгож байгаа.

Яагаад ингэж хэлж байгаа юм гэхээр сая Ерөнхий сайд бүх аймгуудаар явж ажиллахад би хамт явлаа л даа.

Тэгэхээр нэг аймаг дээр хийсэн уулзалт 8, 9 цаг үргэлжилж байгаа юм. 30-аас 40, 50 хүн асуулт, санал хэлж байгаа юм. Тэгээд энэ бүхнийг Ерөнхий сайд эхнээс нь дуустал хамт байж байгаад тэгээд иргэдээр тэр аймагт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг эрэмбэлээд үүнийг гаргаж ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр соёлын салбарт ч тэр, биеийн тамирын салбар ч тэр, бусад салбаруудад хийж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг бидний бусад 76 тойрогт жишиг болохоор гаргаж хэрэгжүүлж бодит ажил болгосон. Иргэдийнхээ оролцоог хангаж иргэдээр эрэмбэлүүлдэг энэ зарчмаар Та бүхэн маань хийсэн ийм зүйл байна уу? Эсвэл өөр бодлого, санаа зорилготой.

Сая Байнгын хороон дээр шүүмжлэл дагуулаад байгаа шиг та нарын төсөв зардал, хөрөнгө зарцуулалттай холбоотой асар их шүүмжлэл гарч байна шүү дээ. Хариулт нь хангалттай өгч чадахгүй байна. Энэ юмаар асуудлууд явагдаж байна уу, үгүй юү гэдэг нэг ийм зүйлийг тодруулж хэлж өгөөч ээ гэж.

Дараа нь яах вэ түрүүн цаг хугацаанд багтаагүй нэг тайлбар өгөх юм бол хүмүүс маань хуучин төрөөс хариуцаад төр, улсын шигшээ баг бариад олимп, дэлхийн аварга, бусад уралдаан тэмцээнүүдэд оролцуулдаг энэ жишгээр яваад байгаа юм шиг ийм ойлголт байна.

Тэгэхээр энэ ойлголт өөрчлөгдсөн. Биеийн тамир, спортын улсын хороо Монгол Улсын Засгийн газар энэ төрийн зарим чиг үүргийг төрийн бус

байгууллагаар гүйцэтгүүлэх энэ хууль, журмын хүрээнд өнөөдрийн байдлаар 25 спортын төрөл гэдэг бол 25 спортын холбоо.

Энэ 25 спортын холбоотой гэрээ байгуулаад ингээд шигшээ багийг нь байгуулж ажиллаж байгаа.

250 гаран хүний бүрэлдэхүүнтэй багш, дасгалжуулагчтайгаа. Тэгээд тэр гэрээг санхүүжүүлэх журмыг нь Засгийн газраар батлуулсан. Энэ хүрээндээ энэ 25 спортын төрөл, түүний 9 спортын төрөл нь паралимпын буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын пара төрлүүд байж байгаа шүү дээ.

Тэгээд л тэр бүх холбоодуудтай гэрээ байгуулаад л гэрээгээ дүгнээд л санхүүжүүлээд явж байгаа юм шүү.

Энэ нэг зааг ялгааг нь ойлгохгүй бол болохгүй байна гэж.

Түүрүүн Л.Энх-Амгалан сайд бид хоёр ярьсан дээр танай биеийн тамирын хичээлийн тоног төхөөрөмж Боловсролын яамны дээрээ төсөв дээрээ сууна шүү дээ. Үүнийг хааш нь ч зайлуулж бултах тийм юу байхгүй.

Үнэхээр Б.Баярсайхан гишүүний асуусан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан бүх цэцэрлэг, сургуулийн биеийн тамирын хичээлийн тоног төхөөрөмжийг шинэчилнэ гээд л зорилт тавьчихсан бол үүнийг л Та бүхэн маань энэ төсөв дээрээ суулгаад хэрэгжүүлээд л явах ёстой ийм зүйл байгаа шүү.

Г.Мөнхцэнэг: Б.Бат-Эрдэнэ сайдын асуултад М.Батбаяр сайд гүйцэд тоо баримттай хариулна.

М.Батбаяр: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр сүүлийн арваад жилийн туршид энэ соёлын төвийн шинэчлэлтийн ажлууд өрнөж байгаа. Нийтдээ 330 сумд 330 соёлын төвтэй. 15 тосгонд заримд нь соёлын төв байгаа.

Тэгэхээр суманд нийтдээ 1700-аас 6000 хүн байгаад нэг л Соёлын төв байгаа. Энд үндсэндээ соёлын боловсрол олгохтой холбоотой соён гэгээрлийн үйл ажиллагаагаа эндээс авдаг. Соёлын төв бол сум нь чухал.

Өнөөдөр 2024 оны улсын төсөв дээр 20 шинэ соёлын төв тусгагдаад явж байгаа. Та түүрүүн хэллээ. Ерөнхий сайд орон нутагт ажилласан.

Ерөнхий сайд орон нутагт ажиллахтай холбоотойгоор ард иргэд маань соёлын төвүүдийг эрэмбэлсэн байна. Би бол үүнийг сайн зүйл гэж бодож байна. Юу вэ гэхээр сүүлийн хоёр, гурван жилийн туршид Улсын Их Хурлаас Соёлын тухай хууль эрх зүйн шинэчлэл, соёлын бодлогын талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд, Засгийн газар бас ажиллаж байгаагийн үр дүнд өнөөдөр сумын ард иргэд соён гэгээрлийн ордон, орчин, орон зай, дэд бүтцийнхээ асуудал соёлын төвүүдээ эрэмбэлнэ гэдэг бол энэ бол сайн зүйл гэж би бодож байна.

Өнөөдөр огт соёлын төвгүй ч 2 сум байна. Хөвсгөлийн Галт, Хөвсгөлийн Ханх сум гээд 2 сум шатчихсан. Соёлын төвгүй байна.

Тэгэхээр арваад жилийн туршид үндсэндээ 300 гаруй соёлын төв ингээд шинэчлэгдээд дуусаж байгаа юм.

Одоо энэ төсөв дээр тусгаж байгаа 20 соёлын төв нь 2024 ондоо бүхэлдээ дуусна гэсэн үг биш ээ. Нэг, хоёр жил үргэлжлээд цаашдаа тухайн сум орон нутагт соёл гэгээрлийн орчин орон зайтай болно гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Г.Мөнхцэцэг: Дараагийн саруудад Байнгын хорооны хуралдаанаар Соёлын яамтай холбоотой асуудлууд, ялангуяа “Кино урлагийг дэмжих сан”, тэр “Соёл урлагийг дэмжих сан, сая тэр байгуулагдсан гэж байгаа тэр Мэдээллийн үндэсний хорооны үйл ажиллагаа гээд энэ үйл ажиллагаануудтай бас танилцах ийм асуудлуудыг гишүүдийн саналаар оруулж ирж хэлэлцэнэ.

Шаардлагатай гэж үзэх юм бол бид Байнгын хороон дээрээ ажлын хэсэг гарч хяналт тогтоох ийм ажлын хэсэг гаргаж ажиллана гэж энэ үгийг хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Гишүүдээс төсөвтэй холбоотойгоор бас зарчмын дүрдээ санал гаргаж байгаа учраас санал хураалт явуулах байгаа.

Гурван санал гаргаж байгаа юм байна. Ч.Ундрам гишүүн.

Тэгээд энэ саналын томьёоллыг танилцуулъя. Протоколд үлдэх учраас уншиж танилцуулах ёстой байгаа.

Соёлын салбарын тоног төхөөрөмжийг Сэлэнгэ аймаг гэсэн байна. 2024 онд 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн байна.

Соёлын салбарын тоног төхөөрөмжийг улсын хэмжээнд 400.0 сая

төгрөг гэснээс 400.0 сая төгрөгийг бууруулах саналыг Ч.Ундрам гишүүн гаргаж байгаа юм байна.

400.0 сая төгрөгийг соёлын салбарт тоног төхөөрөмжөөс ийшээ Сэлэнгэ аймгийг нэмэгдүүлэхээр.

Соёлын сайдын багцаас соёлын салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд 2024 оны төсөв дээрх 400.0 сая төгрөгийг Сэлэнгэ аймаг дахь соёлын салбарын тоног төхөөрөмжид 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэж ингэж горимын санал гаргаж байгаа юм байна.

Энэ саналаа Ч.Ундрам гишүүн тайлбарлаад явчих. Соёлын салбарын тоног төхөөрөмж.

Ч.Ундрам: Яг наадах дээр чинь 10 тэрбум төгрөг нийт 21 аймаг, 9 дүүрэгт байгаа.

Үгүй ээ, энэ чинь тэгээд яг аль аймагт нь, аль дүүрэгт нь ойлгомжгүй. Өмнө нь Сэлэнгэ аймагт төлөвлөчихсөн байсан ажлуудыг энэ хүн ерөөсөө хийж хэрэгжүүлдэггүй.

Тийм учраас би аймагтаа. Тэнд соёлын төвүүд сандалгүй өчнөөн жил болоод байж байна. Тоног төхөөрөмж нь хуучирчихсан байна. Би бүр хувиасаа зай зарим юмыг нь худалдаж авч өгөөд засуулаад явж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ 10 тэрбум төгрөг чинь тодорхой биш байна. Үзэмжээрээ шийдэгдээд байна. Ямар ч төлөвлөлт байхгүй байна.

Тийм учраас бүрэн эрхийнхээ хүрээнд би санал гаргаж байна.

Г.Мөнхцэцэг: Ч.Ундрам гишүүн саналаа тайлбарласан. Санал хураалт явуулах ёстой.

Соёлын сайд өөрөө байхгүй байна. Соёлын сайд байхгүй учраас Засгийн газрын гишүүний хувьд Л.Энх-Амгалан сайд тайлбарлана гэж байхгүй шүү дээ. Тийм. Дандаа соёлын салбарынхтай явж байгаа юм байна. Тийм.

Энэ дээр М.Батбаяр сайд. Соёлын сайд байхгүй учраас Засгийн газрын гишүүний хувьд Л.Энх-Амгалан сайд саяын саналын томъёолол дээр тайлбар.

Л.Энх-Амгалан: Үгүй ээ үгүй. Ч.Ундрам гишүүн ээ ингэж болохгүй.

Та ингээд бас нэг ийм ганц амиа бодсон, ганц тойргийнхоо эрх ашгийг яасан ийм санал гаргаж болохгүй шүү дээ. Та.

Бүхэл бүтэн Засгийн газар дээр сайдууд өөрсдийнхөө багцуудын юмыг төлөвлөлтөөр ингээд орж ирж байхад, бүхэл бүтэн Засгийн газар улсын хэмжээнд зарах гэж байгаа мөнгөнөөс багасгаад тэрийг Сэлэнгэ дээр тавина гэдэг дээр та санал хураалгаж болохгүй шүү дээ.

Энэ Соёлын яам та нар хариулаач. Энэ чинь яаж ингэж болох юм. Үгүй ээ үгүй. Энэ болохгүй шүү дээ. Дараа нь тэр чинь хуваарилалтаараа л явна уу гэхээс биш юу гэдэг юм, 10 тэрбумаас эндээс хасаад дахиад Сэлэнгэ дээр би 300 саяыг тавина.

Тэгээд бүх гишүүд тэгвэл тэг л дээ. Үгүй ээ. Юу гэсэн үг юм. Та нар ийм.

Тэгвэл одоо энэ чинь Засгийн газар гэж байгаад байх ямар хэрэг байна.

Тэгвэл төсвийн нэгдсэн бодлого гэж байгаад ямар нэмэр байна.

Би танд ганцхан арга зам зааж өгье. Ч.Ундрам гишүүн ээ.

Одоо бүх Улсын Их Хурлын гишүүд өөрсдийнхөө нөгөө сонгогчдоос гаргаж ирсэн саналыг одоо Сангийн яаманд эрэмбэлүүлж байгаа шүү дээ. Тэр эрэмбэ дотроо л одоо өөрийнхөө холбоотой тойрогтоо тэр юунуудаа л тавь.

Түүнээс биш та дараагийн удаа дахиад Боловсролын сайдын багцаас хэд гэлээ. 600 саяыг хасуулаад нөгөө талдаа Сэлэнгэ аймаг дээр тавиулж байна гэж байна. Ийм санал хураалт хийж болох юм уу? Болохгүй шүү дээ энэ чинь.

Ямар бүрэн эрх? Би ч гэсэн Улсын Их Хурлын гишүүн шүү дээ. Үгүй ээ, та яах гэж бүхэл бүтэн 21 аймаг төсөвлөсөн.

Г.Мөнхцэцэг: Л.Энх-Амгалан сайд аа.

Л.Энх-Амгалан: Ийм өлөн байж болохгүй шүү. Ундармаа чи ийм өлөн байж болохгүй шүү. Чи Улсын Их Хурлын гишүүн.

Чи өнөөдөр Монгол Улсын ард түмний эрх ашгийн төлөө үйлчилнэ гэж тангараг өргөсөн гишүүн шүү дээ.

Чи Сэлэнгэ аймагт ганцаараа үйлчилнэ гэж тангараг өргөөгүй юм байгаа биз дээ. Чи өнөөдөр Монгол Улсын Их Хурлын гишүүн. Тийм ээ. Тэгээд бүхэл бүтэн нэг сайдын төсөвлөсөн багцаас 300 саяыг аваад.

Одоо 3 сайдын багцаас ийм санал хураалт хийлгэх гээд чи зарчмын

зөрүүтэй санал гаргаж байна шүү дээ. Ингэж болохгүй. Ингэж болохгүй. Энэ Сангийн яаманд тайлбарладаа. Үүнийг.

Г.Мөнхцэцэг: Л.Энх-Амгалан сайд аа, ямар ч байсан хурлынхаа...

Л.Энх-Амгалан: Чи ийм өлөн байж болохгүй шүү.

Г.Мөнхцэцэг: Хурлынхаа дэгийн дагуу гишүүдийн гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулах ёстой.

Тийм учраас саяын Ч.Ундрам гишүүний гаргасан саналын томьёолол дээр дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй.

Дараа нь бас Ч.Ундрам гишүүний гаргасан санал байна.

Соёлын салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд тавигдсанаас энэ 200 сая төгрөгийг Алтанбулагийн музейн засварт Сэлэнгэ аймаг 200 сая төгрөгийг бууруулах саналтай байгаад байгаа юм байна. Нэмэгдүүлэх саналтай байгаад байгаа юм байна.

Тэгээд энэ саналыг Ч.Ундрам гишүүн энэ саналаа тайлбарла. Хоёр дахь санал хураалт чинь явж байна.

Ч.Ундрам: Л.Энх-Амгалан сайд аа, нэгдүгээрт энэ таны багцын асуудал биш.

Соёлын сайд нь өөрөө энд ирж өөрийнхөө асуудлыг тайлбарлахгүй байна. Ерөөсөө энд байгаа гишүүдийг хүндлэхгүй байна. Ирээд нэг ч асуудалд

сүүлийн хэдэн Байнгын хороо дамжаад нэг ч асуудлаа ярихгүй байна.

Хоёрдугаарт, одоогийн санал хураалт бол энэ Хувьсгалын музейтэй холбоотой 2 жил тавигдчихаад мөнгө нь. Тэрийг нь зориулаагүй, зарцуулаагүй, ажлаа хийхгүй байгаа асуудал шүү.

Тийм учраас та бүгдийг дэмжээд өгөөч ээ гэж би хүсэж байна.

Г.Мөнхцэцэг: Санал хураалт.

Энэ санал хураалтыг цуцалъя. Саналын томьёоллыг би түрүүн уншиж танилцуулсан. Соёлын салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд тавигдсанаас 200 сая төгрөгийг Сэлэнгэ аймаг дахь Алтанбулагийн музейн засварт 200 сая төгрөгийг нэмэгдүүлэхээр ингэж оруулж ирсэн саналын томьёоллыг Ч.Ундрам гишүүн гаргасан юм. Тийм.

Сая Ч.Ундрам гишүүн бас энэ гаргасан саналын томьёоллоо тайлбарласан. Энэ дээр 4 номерын микрофон дээр Сангийн яаманд хариулт өгье.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

Ч.Ундрам гишүүний гаргасан саналтай холбоотойгоор тайлбар хийе.

Эхнийх нь тоног төхөөрөмж болон их засварыг салбарын сайдын хүрээнд нэгдсэн бодлогоор удирдах зорилгоор бөөн дүнгээр баталдаг. Аль нэг аймаг дээр тусгайлан тавьдаггүй.

Хоёр дахь асуудал. Их засварын асуудлыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний

удирдлагын тухай хуулийн 20.1.18-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын их засвар орон нутгийн чиг үүргээ гээд заачихсан байгаа.

Тэгэхээр бид улсын төсөв дээр тэрийг тавих боломжгүй. Зөвхөн улсын хэмжээний том юун дээр л тавьж болно.

Г.Мөнхцэцэг: Хурлын дэгээрээ гишүүдийн гаргаж байгаа саналаар санал хураалт явуулах ёстой.

Тийм учраас Ч.Ундрам гишүүний гаргасан саяын санал дээр санал хураалт явуулъя. Санал хураалт. Дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ санал дэмжигдсэнгүй.

Ч.Ундрам гишүүн таны гурав дахь саналыг яах юм? Санал хураалт. Дэгээрээ хурал явах ёстой.

Тэгээд Ч.Ундрам гишүүн гурван санал гаргасан байна. Энэ гурав дахь санал нь болохоороо боловсролын салбарт гаргасан байна.

Энэ нь болохоороо Боловсрол, шинжлэх ухааны салбарын тоног төхөөрөмжөөс 700.0 сая төгрөгийг сургууль, цэцэрлэг, багш нарын тоног

төхөөрөмж рүү Сэлэнгэ аймагт 1 тэрбум болгож нэмэгдүүлэхээр ингэж санал гаргасан байгаа юм.

Тэгээд Ч.Ундрам гишүүн өөрөө саналаа. Энэ саналаа Ч.Ундрам гишүүн тайлбарлахгүй гараад явчихсан учраас үүнийг хураалгах шаардлагагүй гэж үзэж байна.

Гишүүд санал хураалт явуулж дууслаа. Санал хураалт явуулж дууссан.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг. Төсөв дээр хэн байгаа билээ?

Э.Батшугар гишүүн Төсвийн байнгын хороонд танилцуулчих уу? Эхнийхээ ирцээр явна. Тийм. Эхнийхээ ирцээр явж байгаа.

Э.Батсугар гишүүн Төсвийн байнгын хороонд танилцуулна.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүдэд болоод ажлын хэсэгт баярлалаа. Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаан 2 цаг 07 минут үргэлжилж, 15 цаг 40 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД